

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ТӨРӨӨС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, АЖЛЫН БАЙРЫГ
НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН
БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮНГҮЙ БАЙНА.

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг
нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын
хэрэгжилт, үр дүн”-нд хийсэн аудитын тайлан

АУДИТЫН КОД: АГГ-2022/20-ШТА-ГА

Чойбалсан хот 2022 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер И.Сэмжидмаа
Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
Ахлах аудитор Я.Зориг
Утас: 7058-4207, Цахим хаяг: zorigya@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Батжаргал
Утас: 7058-4207, Цахим хаяг: batjargalb@audit.gov.mn
Аудитор С.Энхбаатар
Утас: 7058-4207, Цахим хаяг: enkhbaatarsu@audit.gov.mn
Аудитор М.Ухаанбилэг
Утас: 7058-4207, Цахим хаяг: ukhaanbilegm@audit.gov.mn
Аудитор Ч.Удвалноров
Утас: 7058-4207, Цахим хаяг: udvalnorovch@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	4
Хүснэгтийн товъёг	5
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	6

БҮЛЭГ А. ТӨРӨӨС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ОРОН НУТАГТ ТУСГАЙЛАН ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ БАТЛАГДААГҮЙ, ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ЭХ ҮҮСВЭРИЙГ ҮНДЭСЛЭЛТЭЙ ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА.....	7
--	---

1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр орон нутагт дунд хугацааны стратегийн бодлогын баримт бичиг батлагдаагүй ч, хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүд нь аймгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байна.....	7
1.1. Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлого, шийдвэрийг аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, аймгийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгасан байна.....	7
1.2. Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээний судалгааг 2018, 2020 онуудад мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн боловч зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж үр дүнг үнэлээгүй байна.....	8
1.3. Дорнод аймагт хөдөлмөр эрхлэлтийн талаар тусгайлсан дунд хугацааны стратегийн бодлогын баримт бичиг батлагдаагүй байна.....	9
2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг үндэслэлтэй төлөвлөөгүй байна.....	9
2.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг үндэслэлтэй тооцоогүй байна.....	9
2.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг оновчтой тодорхойлж, тусгасан байна.....	10
2.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн санхүүжилтийг нэгдсэн дүнгээр баталж, цаг хугацаанд нь хуваарилахгүй байна.....	11
3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төрийн байгууллагуудын чиг үүрэг уялдаатай боловч Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөл нь хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.....	11
3.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны төлөвлөгөө уялдсан байна.....	11
3.2. Орон нутгийн онцлогт тохирсон төсөл, хөтөлбөрүүд батлагдсан байна.....	12
3.3. Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл нь хууль, дүрэмд заасан хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй байна.....	12
3.4. Аймгийн ИТХ-аар батлагдсан “Залуу малчин”, “Нэг өрх-Нэг ажлын байр” хөтөлбөрийн хэрэгжилтэд зохих хяналт, шинжилгээ үнэлгээ хийгдсэн байна.....	13

БҮЛЭГ Б. ТӨРӨӨС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, АЖИЛГҮЙДЛИЙГ БУУРУУЛАХ, АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААГ БОДИТОЙ ҮНЭЛЖ, ДҮГНЭЭГҮЙ, ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ ҮР АШИГГҮЙ БАЙНА.....	13
---	----

4. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд хамаарах үйл ажиллагаа үр нөлөөгүй байна.....	13
4.1. Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, ажилд зуучлах арга хэмжээнд үр дүнг тооцох нөхцөл бүрдээгүй байна.....	14
4.2. Нэгдсэн бүртгэл, мэдээллийн системийн хөгжүүлэлт хийгдээгүйн улмаас тоо, мэдээлэл нь зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.....	15
4.3. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд зарцуулсан хөрөнгийн үр ашиг бодитой тооцогдохгүй байна.....	16
5. Орон нутагт нийтийг хамарсан ажил, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар хэрэгжүүлсэн арга хэмжээ үр нөлөөгүй байна.....	17
5.1. Гадаадын санхүүжилттэй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт үр дүнтэй байна.....	17
5.2. Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг бодитой үнэлж ажиллаагүй байна.....	19
5.3. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар тусгайлан авч хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй байна.....	20
6. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан (ХЭДС)-гийн орлогын төлөвлөгөөг дунджаар 91.6 хувийг биелүүлж, 9.2 сая төгрөгийг хууль, журмын дагуу зарцуулаагүй байна.....	21
6.1. ХЭДС-ийн орлогын төлөвлөгөө 2016-2021 онд дунджаар 91.6 хувийн биелэлттэй байна....	22
6.2. ХЭДС-ийн хөрөнгийн 9.2 сая төгрөгийг хууль, журмын дагуу зарцуулаагүй байна.....	23

7. Мэргэжлийн боловсрол сургалтыг дэмжих сан (МБСДС) болон Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагаас хөдөлмөрт бэлтгэх үйл ажиллагаа үр нөлөө багатай байна.....	24
7.1. Орон нутгийн хэмжээнд МБСДС-ийн хөрөнгийг үр ашигтай, үр дүнтэй ашиглаж, нөлөөллийг үнэлэх үйл ажиллагаа хангалтгүй байна.....	24
7.2. Орон нутагт МБС-ын байгууллагын санхүүжилт үр нөлөө багатай байна.....	26
8. "Ковид-19" цар тахлын үед хөдөлмөр эрхлэлтийн талаар төрөөс авч хэрэгжүүлсэн арга хэмжээ орон нутгийн түвшинд хэрэгжсэн байна.....	27
8.1. Цар тахлын үед ажлын байрыг хадгалах талаар Засгийн газраас гаргасан тогтоол шийдвэрийн үр дүнд 1102 аж ахуйн нэгж хөнгөлөлт, чөлөөлөлт, тэтгэмжид хамрагдсан ч зарим ААН-үүд ажлын байраа хадгалж үлдээгүй байна.....	28
8.2. Цар тахлын үед орон нутагт ажилтныг дэмжих чиглэлээр авсан арга хэмжээ үр дүнтэй байна.....	29
8.3. Цар тахлын үеийн сөрөг нөлөөллөөс зорилтот бүлгийн хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг хамгаалах чиглэлээр хөтөлбөрүүд хэрэгжиж, 772 иргэн ажлын байраар хангагдсан байна.....	30
8.4. Цар тахлын улмаас хөдөлмөр эрхлэлтийн салбарт гарсан өөрчлөлт, статистик тоо мэдээг зөрүүтэй байдлаар гаргасан байна.....	31
9. Шилэн дансны тухай хуулийг бүрэн мөрдөж ажиллаагүй байна. /Нэмэлтээр/.....	32
Холбогдох байгууллагын санал:.....	33
Саналд өгсөн тайлбар:.....	34
ДҮГНЭЛТ:.....	35
САНАЛ:	36
ЗӨВЛӨМЖ:	36
Акт, албан шаардлага:.....	37
Тушаал.....	38

Товчилсон үгийн тайлбар

ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АИТХ	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МБС	Мэргэжлийн боловсролын сургалт
МБСБ	Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага
МБСДС	Мэргэжлийн боловсролын сургалтыг дэмжих сан
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
МУИС	Монгол Улсын Их сургууль
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТАБ	Төрийн аудитын байгууллага
УИХ	Улсын Их Хурал
ХАБЭА	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХХК	Хариуцлагатай хувьцаат компани
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ХЭҮЗ	Хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөл

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Ажлын байрны захиалгын мэдээ /ажил, мэргэжлийн ангиллаар/	8
Хүснэгт 2	Нийтлэг үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоон мэдээлэл	14
Хүснэгт 3	Ажлын байранд зуучлагдсан иргэдийн тоон мэдээлэл	14
Хүснэгт 4	Бүртгэлтэй ажилгүй иргэдийн судалгаа	15
Хүснэгт 5	Нийтлэг үйлчилгээнд хамрагдсан иргэн, зарцуулсан төсөв	16
Хүснэгт 6	Бараа материалд зарцуулсан дүн	17
Хүснэгт 7	Нийтлэг үйлчилгээнд хамрагдсан иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамрагдсан хувь	17
Хүснэгт 8	Ядуурлын хамралтын хүрээ	17
Хүснэгт 9	Нийтийг хамарсан үйлчилгээнд хамрагдсан иргэний тоо, мөнгөн дүн	19
Хүснэгт 10	ХЭДС-аар хэрэгжсэн хөтөлбөр, төслийн хэрэгжилт	20
Хүснэгт 11	ХЭДС-ийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл 206-2021 он	21
Хүснэгт 12	ХЭДС-ийн зардлын гүйцэтгэл 2016-2021 он	22
Хүснэгт 13	Дорнод аймгийн МБСБ-уудын 2016-2021 оны санхүүгийн тайлангийн шинжилгээ	23
Хүснэгт 14	МБС-ын байгууллагын орлогын бүтцийн шинжилгээ (хувиар)	25
Хүснэгт 15	МБС-ын байгууллагын зардлын бүтцийн шинжилгээ (хувиар)	25
Хүснэгт 16	ААНБ-уудад ОАТ, НДШ-ийн хөнгөлөлт үзүүлсэн байдал	28
Хүснэгт 17	Ажлын байрыг хадгалсан талаарх ААН-үүдийн судалгаа	28
Хүснэгт 18	Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 (арван) их наядын цогц төлөвлөгөө, зорилтот бүлгийн хөдөлмөр эрхлэлтийн талаар хэрэгжүүлсэн хөтөлбөрийн хэрэгжилт	30
Хүснэгт 19	Үндэсний статистикийн хороо, аймгийн ХХҮГ-аас гаргасан Дорнод аймгийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа 2019-2021 он	32

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Дорнод аймгийн хэмжээнд 2016-2021 оны ажлын байрны захиалгын мэдээ	7
Дүрслэл 2	Хөдөлмөрийн зах зээлд нэн хэрэгцээтэй мэргэжил	8
Дүрслэл 3	Төсвийн төсөл, батлагдсан төсвийн харьцуулалт	10
Дүрслэл 4	Дорнод аймгийн ажилгүй иргэдийн тоон мэдээлэл	15
Дүрслэл 5	ХЭДС-ийн 2016-2021 оны төсвийн гүйцэтгэл дэх нийт зардлын харьцаа	23
Дүрслэл 6	Суралцагчийн тоо болон суралцагчид сард олгох тэтгэлгийн хэмжээний өөрчлөлтийн хоорондын хамаарал	24
Дүрслэл 7	Дорнод аймаг дахь МСҮТ-ийн төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн хувь	26
Дүрслэл 8	Дорнод аймаг дахь Политехник Коллежийн төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн хувь	26
Дүрслэл 9	Төсвийн санхүүжилт болон ажлын байртай болсон төгсөгчдийн тоо хоорондын хамаарал	27

**Аудит хийх
үндэслэл, бүрэн эрх**

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2021 оны “Аудитын сэдэв батлах тухай” 6 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2022 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/12 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас гүйцэтгэх аудитын сэдвийг үндэслэн хийлээ.

Аудитын зорилт

Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүнг тооцож, дүгнэлт, зөвлөмжийг боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэнэ.

Аудитын зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэлээ. Үүнд:

1. Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын баримт бичиг мөн төрийн байгууллагуудын бүтэц, чиг үүргийн уялдаа холбоо хангагдсан эсэх;
2. Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн, хөрөнгийн зарцуулалт үр ашигтай байгаа эсэх;

Аудитын хамарсан хүрээ

Аудитад Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 320 дугаар тогтоолоор баталсан Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлогын баримт бичигт тусгасан төсөл, хөтөлбөр зорилго, зорилт, арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэх, биелэлтийн явц, үр дүнг тооцон тайлагнах, үнэлж дүгнэх үүрэг хүлээсэн хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хөдөлмөр эрхлэлтийн үндэсний болон аймаг, нийслэл, дүүргийн зөвлөл, хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, сум, хорооны хөдөлмөр эрхлэлтийн ажилтан /хөдөлмөрийн алба/, хөдөлмөрийн биржийн 2016-2021 оны үйл ажиллагааг хамрууллаа.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, 300, 3000-3100, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан тэдгээрийн нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт хийх арга зүйг ашиглалаа.

Аудитын бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Болортуул хянан удирдаж, аудитын менежер И.Сэмжидмаа үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн аудитын албаны ахлах аудитор Я.Зориг, Б.Батжаргал, аудитор С.Энхбаатар, М.Ухаанбилэг, Ч.Удвалноров нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.

Аудитын төлөвлөгөөг 2022 оны 3 дугаар сарын 02-ны дотор батлуулж, талбарын ажлыг 2022 оны 3 дугаар сарын 3-ны өдрөөс 2022 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэл гүйцэтгэж, тайланг 5 дугаар сарын 02-ний өдрийн дотор боловсруулж, үе шатны хяналтыг хийлгэж, тайлан, холбогдох судалгааг 5 дугаар сарын 5-ны дотор Үндэсний аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүллээ.

А. Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр дунд хугацааны стратегийн бодлогын баримт бичиг батлагдаагүй, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг үндэслэлтэй төлөвлөөгүй байна.

1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр орон нутагт дунд хугацааны стратегийн бодлогын баримт бичиг батлагдаагүй ч, хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүд нь аймгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байна.

1.1. Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлого, шийдвэрийг аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, аймгийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгасан байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3¹-т бодлого төлөвлөлтийг нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байхаар заасан.


Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс Засгийн газрын 2016 оны 320 дугаар тогтоолд заасан төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлоготой уялдуулан хөтөлбөр, төсөл, арга хэмжээнүүдийг аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, аймгийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, хөгжлийн төлөвлөгөөнд тусгаж баталсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөл нь хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тогтоолыг үндэслэн орон нутагт хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, төсөв, хөтөлбөрүүдийг баталсан байна. Үүнд: “Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр”, “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээг дэмжих хөтөлбөр”, “Ажилд зуучлах үйлчилгээ”, “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”, “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр”-үүд багтаж байна.

1.2. Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээний судалгааг 2018, 2020 онуудад мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн боловч зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж үр дүнг үнэлээгүй байна.

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг бий болгогчид нь ажил олгогч нар юм. Ажил олгогчид нь аж ахуйн нэгж байгууллага, өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж өөртөө болон бусдад ажил олгогч, өрхийн аж ахуй эрхлэгч нар юм.

Дүрслэл 1. Дорнод аймгийн хэмжээнд 2016-2021 оны ажлын байрны захиалгын мэдээ



Эх сурвалж: ХХҮГ-ын www.Lmis.gov.mn статистик мэдээ

Дорнод аймгийн хэмжээнд 2016-2021 онд ажлын байранд жилд дунджаар 433 ААНБ-аас 1500 орчим захиалга ирсэн байна. Сүүлийн 6 жилийн хугацаанд 2020 онд хамгийн бага буюу 1236 ажлын байрны захиалга ирсэн байна. Энд Ковид-19 цар тахлын нөлөө хамгийн өндөр байсан байна. 2021 онд өмнөх оноос 57 ажлын байрны захиалга илүү ирж, өмнөх онтой харьцуулахад 4.6 хувиар өссөн бөгөөд 39.8 хувийг хөдөө аж ахуйн, 26.7 хувийг үйлчилгээний бусад үйл ажиллагаа, үлдсэн хувийг бусад салбарын ажлын байрны эрэлт бүрдүүлж байна. (Дүрслэл 1)

¹ 5.1.3. нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх;

Хүснэгт 1. “Ажлын байрны захиалгын мэдээ/ажил мэргэжлийн ангиллаар/”

№	Үзүүлэлт	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он
1	Контор, үйлчилгээний ажилтан	10	115	48	30	80	27
2	Менежер	12	47	49	28	60	54
3	Зэвсэгт хүчний ажил, мэргэжил	18	7	20	28	2	1
4	Суурин төхөөрөмж, машин механизмын оператор, угсрагч	64	151	96	202	50	50
5	Мэргэжилтэн	74	187	322	186	143	120
6	Худалдаа, үйлчилгээний ажилтан	94	125	71	121	127	127
7	ХАА, ой, загас агнуурын ажилтан	81	159	149	203	96	354
8	Техникч болон туслах/дэд мэргэжилтэн	103	80	112	91	45	63
9	Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажилтан	225	262	212	211	158	94
10	Энгийн ажил мэргэжил	586	633	667	592	475	403
Нийт		1267	1766	1746	1692	1236	1293

Эх сурвалж: ХХҮГ-аас гаргасан статистик мэдээнээс

Ажлын байрны захиалгыг 2016-2021 оны байдлаар ажил мэргэжлийн ангиллаар авч үзвэл ажлын байрны эрэлт нь харилцан хамааралгүй байна. (Хүснэгт 1)

Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн зах зээлд нэн хэрэгцээтэй, эрэлттэй ажил мэргэжлийг жагсаахад дараах 10 мэргэжил эрэмбэлэгдсэн байна.

Дүрслэл 2. “Хөдөлмөрийн зах зээлд нэн хэрэгцээтэй мэргэжил”²



Хөдөлмөрийн зах зээлд нэн хэрэгцээтэй дээрх 10 мэргэжлээс худалдагч, кассчинаас бусад 8 мэргэжлийг орон нутгийн МБС-ууд жил бүр бэлтгэн хөдөлмөрийн зах зээлд гаргаж байна. Эдийн засгийн тогтолцооны өөрчлөлтөөс хамаарч, хөдөлмөрийн зах зээлээс өндөр чадвартай ажилчдыг хайдаг болсон. Иймээс орон нутгийн хөдөлмөрийн зах зээлд нэн эрэлттэй байгаа мэргэжлүүдийн чанар буюу ажлын байран дээрх чадамжийн асуудлыг анхаарах шаардлага байна гэж үзэж байна.

Сүүлийн жилүүдэд мал аж ахуй эрхлэхтэй холбоотойгоор туслах малчин, гэрээт малчин гэсэн шинэ ажлын байр эрэлт ихэссээр байна.³

- Дорнод аймгийн ЗДТГ-ын санаачилга, Европын холбооны “SECIM” төслийн дэмжлэгтэйгээр тус аймгийн “Дорнод аймгийн хөдөлмөрийн зах зээл” судалгааг 2018 онд ХНХЯ-ны харьяа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт өөрсдийн боловсруулсан, арга аргачлалын дагуу хийж гүйцэтгэсэн байна.

Уг судалгааны хүрээнд 10 санал, зөвлөмж өгөгдсөн байна.

Зөвлөмжийн хэрэгжилтийн хүрээнд залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр боловсруулж орон нутгийн МБСБ-уудтай хамтарсан гагнуур, тогооч, оёдол, гоо сайхны сургалтуудыг нийт 351 иргэнийг хамруулан зохион байгуулж чадамжийн гэрчилгээ олгосноос 86 иргэнийг байнгын ажлын байраар хангаж, үлдсэн иргэдийг сургалтын болон түр ажлын байраар хангасан байна.

- Мөн аймгийн ХХҮГ-аас албан бус хөдөлмөр эрхэлж буй иргэдийн мэдээллийн сан бүрдүүлэх зорилгоор 2020 онд “Албан бус салбар дахь хөдөлмөр эрхлэлт-2020” судалгааг аймгийн төв болон сумдын хэмжээнд МУИС болон Социологийн Боловсролын төвийн багш, судлаачид, түүвэр судалгааг явуулсан байна.

Уг судалгааны хүрээнд орон нутгийн удирдлагын түвшинд - 3, хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын түвшинд - 8, сум, орон нутгийн түвшинд - 6 нийт 17 зөвлөмжийг тусгасан байна. Зөвлөмжийн хэрэгжилтийн хүрээнд цаг үе, цар тахалтай холбоотойгоор ажил олгогч, хөдөлмөрийн хувийн биржүүд, ажил хайгч иргэдийг холбосон цахим арга хэмжээ 28 удаа зохион байгуулж 377 ажлын байр нээлттэй зарлаж, 638 иргэнд санал болгосноос 52 иргэнийг байнгын ажлын байранд зуучилсан байна.

² “Албан бус салбар дахь хөдөлмөр эрхлэлт-2020” суурь судалгааны тайлан, Дорнод аймаг, хуудас 22.

³ “Дорнод аймгийн хөдөлмөрийн зах зээл” –ийн судалгааны тайлан, 2018 он. Дорнод аймаг, хуудас 38

1.3. Дорнод аймагт хөдөлмөр эрхлэлтийн талаар тусгайлсан дунд хугацааны стратегийн бодлогын баримт бичиг батлагдаагүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4 дэх төрийн захиргааны байгууллага, Хурлын болон Засаг даргын бүрэн эрхэд “Хөдөлмөрийн зах зээлийн төлөв байдалд дүн шинжилгээ хийх, чиг хандлагыг тодорхойлох, богино, дунд хугацааны болон хэтийн зорилтыг боловсруулах”, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.д “Нутаг дэвсгэрийнхээ хүн амын нийгмийн хамгааллын хөтөлбөрийг боловсруулж Хурлаар шийдвэрлүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн халамжийн зэрэг хууль тогтоомжид заасан санг бүрдүүлэх, захиран зарцуулах ажлыг ерөнхий удирдлагаар хангах” гэснийг үндэслэн аймгийн Засаг даргын 2019 оны А/448 дугаар захирамжаар Дорнод аймагт 2018-2020 онд Европын холбооны санхүүжилтээр хэрэгжсэн “Монгол Улсад ажлын байрыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх нь” төслийн хүрээнд “Аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дунд хугацааны бодлогын баримт бичиг” боловсруулах ажлын хэсэг⁴ байгуулагдан ажилласан байна.

Энэхүү ажлын хүрээнд иргэдийн санал хүсэлтийг авч, 13 сум болон Хэрлэн сумын 11 багт “Хөдөлмөр эрхлэлтийн тулгамдаж буй асуудал” сэдэвт хэлэлцүүлэг, салбар дундын хамтын ажиллагааг хөгжүүлэх, үйл ажиллагааг сайжруулах зорилгоор 2 удаагийн 112 төрийн болон төрийн бус байгууллага, ажил олгогч, иргэний төлөөлөл оролцсон хэлэлцүүлгийг тус тус зохион байгуулж хэрэгжүүлсэн боловч уг баримт бичиг бүрэн боловсруулагдаж батлагдаагүй байна.

2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг үндэслэлтэй төлөвлөөгүй байна.

2.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг үндэслэлтэй тооцоогүй байна.

Аймгийн хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангийн төсвийн төслийг боловсруулж, Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлөөр хэлэлцүүлэн жил бүр ХХҮЕГ-т хүргүүлж ажилласан байна.


Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлд төсвийн төслийг дүн шинжилгээ, тооцоонд үндэслэсэн боловсруулж байхаар заасан.

Төсөл, хөтөлбөр хариуцсан холбогдох мэргэжилтнүүдээс төсвийн төслийг хэрхэн боловсруулсан талаар тодруулга авсны дагуу “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн төсвийн төслийг боловсруулахдаа өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тайлант оны хүлээгдэж буй гүйцэтгэлд тулгуурлан боловсруулдаг. Мөн сумын хөдөлмөрийн мэргэжилтнүүдээс санал авч нэгтгэж, судалгаа, шинжилгээ хийж боловсруулдаг” гэсэн тайлбарыг өгсөн хэдий ч холбогдох анхан шатны баримт материалаар нотлогдохгүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 2016-2021 оны хөтөлбөрүүдийн төсвийн төсөл, батлагдсан төсвийг графикаар харуулбал: /тэрбум төгрөгөөр/

⁴ “Дорнод аймгийн дунд хугацааны Хөдөлмөр эрхлэлтийн стратегийн баримт бичгийн төслийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу боловсруулж, 2019 оны 11 дүгээр сард багтаан аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлд тайлагнаж ажиллахыг ажлын хэсэгт даалгасугай” гэсэн байна.

Дүрслэл 3. “Төсвийн төсөл, батлагдсан төсвийн харьцуулалт”



Эх сурвалж: ХЭД чиглэлээр өгсөн төсвийн төсөл, батлагдсан төсөв 2016-2021 он

Дээрх графикаас харахад хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн төсвийн төслийг 900.0-2,300.0 сая төгрөг байхаар төлөвлөж хүргүүлдэг боловч, төлөвлөсөн дүнгээс 200.0-1,200.0 сая төгрөгөөр бага дүнтэй батлагдсан байна.

Төсвийн төсөл боловсруулах заавар, журмыг ХХҮЕГ-аас батлаагүй байна. Төсвийн төсөл боловсруулах удирдамж чиглэл өгөөгүй зөвхөн нэгтгэлийн маягт ирүүлсэн байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн төсвийн төслийг судалгаа, шинжилгээнд үндэслэн үндэслэлтэй тооцон боловсруулаагүй байна.

2.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг оновчтой тодорхойлж, тусгасан байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө, орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө, гадаадын иргэнийг гэрээгээр ажиллуулсан ажил олгогчийн төлөх ажлын байрны төлбөр, гадаад улс, олон улсын байгууллагаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор олгосон зээл зэрэг эх үүсвэрээс бүрдэхээр заасан.

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тогтоолоор баталсан “Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр”, “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээг дэмжих хөтөлбөр”, “Ажилд зуучлах үйлчилгээ”, “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”, “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр”-үүдийг Улсын төсвөөс санхүүжүүлсэн байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.6-д “Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага нь улсын төсвөөс санхүүжнэ.” гэж заасан.

Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсвийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын тушаалаар баталж санхүүжүүлсэн байна.

Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийн шийдвэрээр “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйг дэмжих дэд хөтөлбөр”, “Нэг өрх – Нэг ажлын байр” хөтөлбөрүүдийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн байна. Мөн “Залуучуудын гарааны бизнесийг дэмжих Start-up” төвийг орон нутгийн төсвөөр хөрөнгөөр байгуулсан байна.

Гадаад улс, олон улсын байгууллагаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор Европын холбооны санхүүжилттэй хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, иргэдийн хэрэгцээнд тулгуурлан “Монгол Улсад ажлын байрыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх Secim төсөл”, Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилттэй “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”, Дэлхийн банкны санхүүжилттэй “Хөдөлмөр эрхлэлтийн туршилтын хөтөлбөр”-үүдийг хэрэгжүүлсэн байна.

2.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн санхүүжилтийг нэгдсэн дүнгээр баталж, цаг хугацаанд нь хуваарилахгүй байна.

ХХҮЕГ-ын даргын тушаалаар Дорнод аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсвийг жил бүр баталж ирүүлсэн байна. Улсын төсвөөс батлагдсан санхүүжилтийг жил бүр олгосон байна. Харин 2020 онд Ковид-19 цар тахалтай холбоотой санхүүжилт тасарч 499.8 сая төгрөгийн өглөг үүссэнийг 2021 онд барагдуулсан байна. Төсөл, хөтөлбөрүүдийн санхүүжилт нь хөтөлбөр тус бүрээр орж ирдэггүй, нэгдсэн дүнгээр жилд 2-3 хуваагдаж орж ирсэн байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн удирдамжид зааснаар 4, 9 дүгээр саруудад төсөл хөтөлбөрүүдийн санхүүжилтийг 70/30 харьцаагаар олгодог байна. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн удирдамжид хугацаа зааж өгөөгүй тул хугацаа заасан хөтөлбөрүүдийн дараа зохион байгуулж санхүүжүүлж байна.

Бодит байдал дээр хаврын улиралд малын үнэ хямд, намрын улиралд үнэтэй байгаатай холбоотой санхүүжилт 3 дугаар улиралд буюу оройтож ирснээс шалтгаалан малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг санхүүжүүлэхэд зорилтот үр дүндээ хүрэхгүй байх эрсдэлийг үүсэж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр бий болгох бодлогыг цаг тухайд нь үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн нөөцийг цаг хугацаанд нь зөв зохион байгуулж хуваарилах шаардлагатай байна.

3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр байгууллагуудын чиг үүрэг харилцан уялдаатай боловч Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөл нь хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

3.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны төлөвлөгөө уялдсан байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.3⁵-т хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцооны зохион байгуулалт, үйл

⁵ 5.2.3. "нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх зарчим" гэж хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, мэдээлэл, аргачлал нь нэгдмэл, уялдаатай байж, бодлогыг төлөвлөх, боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагааны нэгдмэл байдлыг;

ажиллагаа, мэдээлэл, аргачлал нь нэгдмэл, уялдаатай байж, бодлогыг төлөвлөх, боловсруулах талаар заасан байна.

Хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлж байгаа аймгийн Засаг даргын Тамгын газар, ХХҮГ, хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөл нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр жилийн үйл ажиллагааны болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж ажилласан байна.

Гэтэл Мэргэжлийн боловсрол, сургалтын үндэсний зөвлөлийн орон нутгийн салбар зөвлөлийг аймгийн Засаг даргын 2018 оны А/69 дүгээр захирамжаар байгуулан ажилласан ч орон нутагт үйл ажиллагаа явуулж буй мэргэжлийн боловсролын байгууллагуудыг удирдлага арга зүйгээр хангаж ажилласан талаарх төлөвлөгөө, тайлан байхгүй байна.

3.2. Орон нутгийн онцлогт тохирсон төсөл, хөтөлбөрүүд батлагдсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3⁶-д заасан төсөл, хөтөлбөрийн хэлбэрээр хэрэгжүүлнэ гэж заасан байна.

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тогтоолоор батлагдсан төсөл, хөтөлбөрүүдийн хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөл нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр орон нутгийн онцлогт тохируулан “Орон нутагт ажлын байрыг дэмжих, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, жижиг зээлийн туршилтын хөтөлбөр”, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих Start-Up” арга хэмжээг хэлэлцэн баталж, аймгийн ИТХ-д санал оруулж батлуулсан байна. Мөн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих орон нутгийн онцлогт тохирсон аймгийн ИТХ-аар “Залуу малчин хөтөлбөр”, “Нэг өрх-Нэг ажлын байр” гэсэн хөтөлбөрүүд батлагдан хэрэгжсэн байна.

Эдгээр төсөл, арга хэмжээ, хөтөлбөрүүдэд аймгийн хөдөлмөрийн насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, өрхийн амьжиргааны түвшин тогтоох, ажилгүйдлийг бууруулах, залуучуудын гарааны бизнесийг дэмжих, бизнес эрхлэх үр чадвар олгох сургалтад хамруулах талаар тусгагдсан байна.

3.3. Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл нь хууль, дүрэмд заасан хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл нь оны эхэнд тогтоол гаргаж тайлант оны төлөвлөгөө, төсөв, хөтөлбөрүүдийг баталж өмнөх онд зохион байгуулсан арга хэмжээнүүдийн үр дүнг хэлэлцэж дүгнэж ажилладаг байна. Шинэ санаачилга гаргаж SECIM төсөлтэй хамтран Масс мессеж үйлчилгээ, гар утасны dornod job аппликейшн, хөдөлмөрийн сэтгэл зүйч, ажлын байранд дасан зохицох, дадлагажуулах арга хэмжээ, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг хадгалах үйлчилгээг хэрэгжүүлж эхэлсэн байна.

Хөдөлмөр эрхлэлтийн Дорнод аймгийн зөвлөл нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн тайланг хэлэлцэж дүгнэлт гаргах, сангийн орлого зарлагад хяналт тавих, хөндлөнгийн шалгалтаар илэрсэн асуудлыг шийдвэрлэх зэрэг асуудлуудад хандаж арга хэмжээ авч ажилласан эсэх нь баримтаар нотлогдохгүй байна.

⁶ 6.3.1.хөдөлмөрт бэлтгэх; 6.3.2.хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах; 6.3.3.малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийг дэмжих, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих; 6.3.4.ажил олгогчийг дэмжих; 6.3.5.нийтийг хамарсан ажил зохион байгуулах; 6.3.6.ажил олоход хүндрэлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих; 6.3.7.хууль тогтоомжид заасан, түүнчлэн Засгийн газрын болон Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн шийдвэрээр тодорхойлсон бусад төсөл, хөтөлбөр.

Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөл нь 2017-2021 онуудад жилд 3.8-4.5 сая төгрөгийн батлагдсан төсөвтэй үүний 95.7 хувийг гишүүдийн урамшуулалд зарцуулж үлдэгдэл 4.3 хувийг бичиг хэрэг болон шатахууны зардалд зарцуулсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөл нь 2016-2021 онуудад жилд дунджаар 2 удаа хуралдаж байгаа нь ЗГ-ын 2011 оны 350 болон 2020 оны 147 дугаар тогтоолд улиралд нэгээс доошгүй удаа хуралдахаар заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Мөн уг журмын 2.1.2-д “ХЭДС-гийн орлого, зарлагын байдалд хяналт тавих”, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 28.8.3-т “хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны талаар хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын тайлан, мэдээлэл болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны үр дүнд хийсэн хөндлөнгийн байгууллагын хяналт, шинжилгээ, үнэлгээний тайланг хэлэлцэж санал, дүгнэлт гаргах, шаардлагатай асуудлыг холбогдох байгууллагад оруулж шийдвэрлүүлэх;”, 28.8.5-д “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хагас болон бүтэн жилийн санхүүгийн тайланг хэлэлцэж санал, дүгнэлт гаргах”, 28.8.6-д “хөдөлмөр эрхлэлтийн болон ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц, үр дүнд хийсэн хяналт, шинжилгээний дүнг хэлэлцэх, түүнд үндэслэн хууль тогтоомж, хөтөлбөрийг боловсронгуй болгох талаар зөвлөмж гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлэх;” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Энэ нь сүүлийн жилүүдэд үргэлжилж буй ковид-19 өвчний улмаас хяналт, шалгалтууд хэрэгжээгүй байна.

3.4. Аймгийн ИТХ-аар батлагдсан “Залуу малчин”, “Нэг өрх-Нэг ажлын байр” хөтөлбөрийн хэрэгжилтэд зохих хяналт, шинжилгээ үнэлгээ хийгдсэн байна.

Засгийн газрын 2016 оны 320 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого”-ын 6.3-д “Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг жил бүр, хөндлөнгийн үнэлгээг 5 жил тутам тус тус хийж, дүнг Засгийн газарт тайлагнана.” гэж заасан нь орон нутагт хамааралгүй байна.

Аймгийн хэмжээнд “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтийн явцад тусгайлан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдээгүй ч түүнтэй холбоотой зарим зорилт, арга хэмжээ нь аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын үйл ажиллагааны тухайн жилийн төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтэд тусгагдаж хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдсэн байна.

Аудитын явцад аймгийн ИТХ-аар баталсан “Залуу малчин”, “Нэг өрх-Нэг ажлын байр” хөтөлбөрийн хэрэгжилтэд зохих хяналт-шинжилгээ, үнэлгээг хийсэн эсэхийг хамааруулж үзэхэд аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс тус хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээг хийсэн байна.

Б. Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааг бодитой үнэлж, дүгнээгүй, хөрөнгийн зарцуулалт үр ашиггүй байна.

4. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд хамаарах үйл ажиллагаа үр нөлөөгүй байна.

4.1. Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, ажилд зуучлах арга хэмжээнд үр дүнг тооцох нөхцөл бүрдээгүй байна.

Дорнод аймгийн ХХҮГ нь ажил хайгч, ажилгүйдэлд өртөж болзошгүй, ажил олоход хүндрэлтэй иргэн, ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагч, эцэг, эх, их дээд сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн төгсөгч, хугацаат цэргийн албан хаагч иргэнд бүлгийн болон ганцаарчилсан зөвлөгөө өгч ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээг хүргэж ажилласан байна. Ингэхдээ бүлгийн сургалтыг

ХХҮЕГ-аас эрх авсан аж ахуйн нэгжүүдээр ажлын байранд өөрийгөө бэлтгэх, харьцааны ур чадвар, сэтгэл зүй, хувь хүний төлөвшил, хөдөлмөрийн харилцаа, аюулгүй ажиллагааны талаар мэдээлэл өгч ажилладаг байна.

Мэргэжлийн сургалтын байгууллагууд ХХҮЕГ-аас зөвшөөрөл авсан аж ахуй нэгжүүдээс санал ирүүлсэн хуулийн этгээдтэй гэрээ байгуулан ажилласан байна. Уг хуулийн этгээдүүдийг сонгон шалгаруулсан талаарх баримт байхгүй байна.

Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газар болон мэргэжлийн сургалтын байгууллагуудаас тайлант хугацаанд зохион байгуулсан хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний сургалт, зөвлөгөөнд хамрагдсан иргэдийг хүснэгтээр харуулбал.

Хүснэгт 2. “Нийтлэг үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоон мэдээлэл”

№	Аймаг, дүүрэг, байгууллагаар	Ганцаарчилсан сургалт, зөвлөгөө авсан нийт иргэн	Бүлгийн сургалт, зөвлөгөө авсан нийт иргэн	Нийт хамрагдсан
2016	Дорнод	148	1107	1255
2017	Дорнод	473	686	1159
2018	Дорнод	650	1042	1692
2019	Дорнод	625	3259	3884
2020	Дорнод	550	1500	2050
2021	Дорнод	606	1450	2056
Нийт		3052	9044	

Эх сурвалж: ХХҮГ-ын 2016-2021 оны үйл ажиллагааны тайлан

Ажилд зуучлах үйлчилгээнд ХХҮГ-т аж ахуйн нэгж байгууллага, иргэнээс сул чөлөөтэй ажлын байрны захиалга ирүүлсний дагуу уг ажлын байрыг бүртгэлтэй ажил хайгч, ажилгүй иргэнээр бүртгэлтэй иргэдэд санал болгож зуучилдаг байна. Мөн уг хөдөлмөр зуучлалын үйлчилгээг Дорнод аймагт “Дорнын гүүр” ХХК, “Байтаг богд” ХХК, “Дорнын цуурай” ХХК, “Геопетро инженеринг” ХХК, “Дорнын нинж төгөлдөр” ХХК, “Бэрх цагаан овоо” ТББ-уудын дэргэдэх хөрөнгийн бирж үзүүлж ажилласан байна.

Дорнод аймгийн ХХҮГ-аас ажлын байранд зуучилсан дүнг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 3. “Ажлын байранд зуучлагдсан иргэдийн тоон мэдээлэл”

Нийтлэг үйлчилгээ	2016	2017	2018	2019	2020	2021
	Иргэний тоо	Иргэний тоо	Иргэний тоо	Иргэний тоо	Иргэний тоо	Иргэний тоо
Ажилд зуучлах;	1206	1554	1561	1571	1089	943
Байнгын ажлын байранд зуучилсан	861	1056	1096	1172	591	495
Улирлын болон Түр ажлын байранд зуучилсан	345	498	465	399	498	448

Эх сурвалж: www.lmis.gov.mn

Хүснэгтээс үзвэл ойролцоогоор нийт хөдөлмөрт зуучлагдсан иргэдийн 30 гаруй хувь нь түр буюу улирлын чанартай ажилд зуучлагддаг байна.

ХХҮГ-ын бүртгэлтэй ажил хайгч иргэний хөдөлгөөний мэдээг www.lmis.gov.mn Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн программаас татан үзэхэд тайлант хугацаанд бүртгэлтэй ажилгүй иргэний тоо буурсан үзүүлэлттэй гарсан байна.

Хүснэгт 4. “Бүртгэлтэй ажилгүй иргэдийн судалгаа”

№	Аймгийн нэр	2016	2017	2018	2019	2020	2021
1	Дорнод аймаг	1381	1729	1488	1203	380	1109

Эх сурвалж: www.lmis.gov.mn

Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Lmis.gov.mn программын Дорнод аймгийн бүртгэлтэй ажилгүй иргэний тоог Үндэсний Статистикийн хорооны www.1212.mn Статистикийг мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэлтэй тулган үзэхэд хоорондоо тохирохгүй байна. Энэ нь дээрх сайтууд харилцан уялдаагүй ажиллаж байгааг харуулж байна. Ингэснээр ажилгүй иргэний тоо мэдээлэл аль нь зөв болохыг тодорхойлох боломжгүй байна.

Дүрслэл 4. “Дорнод аймгийн ажилгүй иргэдийн тоон мэдээлэл”



Эх сурвалж: www.1212.mn

4.2. Нэгдсэн бүртгэл, мэдээллийн системийн хөгжүүлэлт хийгдээгүйн улмаас тоо, мэдээлэл нь зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.

Дорнод аймгийн ХХҮГ-ын Хөдөлмөрийн зах зээлийн бүртгэл мэдээллийн сан буюу Lmis программ нь 2013 оноос хойш ашиглагдаж байгаа бөгөөд аймгийн Хөдөлмөрийн зах зээлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан юм.

Энэхүү программын давуу тал:

1. Ажил хөдөлмөр эрхлэхээр бүртгүүлсэн иргэний мэдээлэл нь хугацаа, нь тодорхой, бүртгэл нь баталгаажуулсан байдлаар харагддаг байна.
2. Бүртгэлд хамрагдаж байгаа иргэний ажлын түүх нь харагддаг байна.

Уг бүртгэлийн нэгдсэн сан нь 2013 оноос хөгжүүлэлт бүртгэл мэдээллийн шинэчлэлт баяжуулалтыг 2016 он хүртэл хийгээд энэ хугацаанаас хойш Хөдөлмөрийн зах зээлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн систем нь зөвхөн Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ /ажилд зуучлах, шинэ ажлын байрны бүртгэл/ хийгдэж байна. Төсөл, хөтөлбөрт хамрагдсан бүх иргэдийн мэдээллийг хамруулахгүй байна. Ажилгүй иргэдийн мэдээлэл www.1212.mn сайтын тоо мэдээлэлтэй тохирохгүй байна.

Сул тал:

1. Иргэний ажилд зуучлагдах үйлчилгээг хийхэд механик ажиллагаа их шаарддаг байна.

2. Ажлын байрны шилжилт хөдөлгөөний мэдээллийг хуулиараа жил бүрийн дараа улиралд бүртгэл хийх ёстой боловч программ хөгжүүлэлт байхгүй тул хийгдээгүй байна.
3. Аймаг үйл ажиллагаа явуулж байгаа хувийн биржүүдийн ажилд зуучлах үйлчилгээний мэдээлэл нь аймгийн нэгдсэн дүнд орж тоологддоггүй /Хөдөлмөрийн хэлтсийн тайланд зөвхөн өөрийн зуучилсан мэдээллээс харж болно./

4.3. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд зарцуулсан хөрөнгийн үр ашиг бодитой тооцогдохгүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6.2⁷-т нийтлэг үйлчилгээнд ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, ажилд зуучлах, ажилгүйдлийн тэтгэмж олгох, нэгдсэн бүртгэл, мэдээллийн үйлчилгээнд хамруулах, бусад үйлчилгээг хамааруулахаар заасан байна.

ХХҮГ-ын Хөдөлмөрийн хэлтсээс 2016-2021 онд хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ болох 6.2.1, 6.2.2 дахь үйлчилгээнд жилд дунджаар 1723 иргэн хамрагдаж, 12.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт 5. “Нийтлэг үйлчилгээнд хамрагдсан иргэн, зарцуулсан төсөв”

Нийтлэг үйлчилгээ	2016		2017		2018	
	Иргэний тоо	Зарцуулсан төсөв	Иргэний тоо	Зарцуулсан төсөв	Иргэний тоо	Зарцуулсан төсөв
6.2.1.ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах;	1282	13.5	1689	9.3	1671	13.6
6.2.2.ажилд зуучлах;	1206	1.3	1554	12.3	1561	10.7
6.2.3. Ажилгүйдлийн тэтгэмж олгох	Иргэний тэтгэмж олгохтой холбоотой тодорхойлолт гаргах үйлчилгээ хамаарна.					
6.2.4. Нэгдсэн бүртгэл, мэдээллийн үйлчилгээнд хамруулах	Ажилгүй иргэдийг программд бүртгэх үйл ажиллагаа хамаарна.					
Нийтлэг үйлчилгээ	2019		2020		2021	
	Иргэний тоо	Зарцуулсан төсөв	Иргэний тоо	Зарцуулсан төсөв	Иргэний тоо	Зарцуулсан төсөв
6.2.1.ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах;	3701	25.6	2050	15.6	2364	15.6
6.2.2.ажилд зуучлах;	1571	11.1	1089	9.6	943	6.6
6.2.3. Ажилгүйдлийн тэтгэмж олгох	Иргэний тэтгэмж олгохтой холбоотой тодорхойлолт гаргах үйлчилгээ хамаарна.					
6.2.4. Нэгдсэн бүртгэл, мэдээллийн үйлчилгээнд хамруулах	Ажилгүй иргэдийг программд бүртгэх үйл ажиллагаа хамаарна.					

Эх сурвалж: ХХҮГ-ын 2016-2021 оны санхүүгийн тайлан, дансны хуулга

Төсвийн зарцуулалтаас үзэхэд бараа материалын зардалд түлхүү зарцуулж байгаа нь харагдаж байна. Тухайлбал 2021 онд ковид-19 өвчний улмаас хөл хорио тогтоож, Засгийн газар, Улсын болон аймгийн Онцгой комиссоос нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулахыг хориглосон шийдвэрүүд гарч байсан. Гэтэл ХХҮГ-аас сургалтын материалын зардалд 9.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

⁷ 6.2.Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг дараах хэлбэрээр хэрэгжүүлнэ:
6.2.1.ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах;
6.2.2.ажилд зуучлах;
6.2.3.ажилгүйдлийн тэтгэмж олгох;
6.2.4.нэгдсэн бүртгэл, мэдээллийн үйлчилгээнд хамруулах;
6.2.5.бусад үйлчилгээ.

Хүснэгт 6. “Бараа материалд зарцуулсан дүн”

Нийтлэг үйлчилгээ	2017	2018	2019	2020	2021
	Зарцуулсан төсөв	Зарцуулсан төсөв	Зарцуулсан төсөв	Зарцуулсан төсөв	Зарцуулсан төсөв
Зарцуулсан төсөв	21.6	24.3	36.6	25.2	22,2
Бараа материалд зарцуулсан дүн	14.5	12.6	9.5	6.2	9.8
Хувь	67.2	51.6	25.9	24.5	44

Эх сурвалж: ХХҮГ-ын 2017-2021 оны санхүүгийн тайлан, дансны хуулга

Дорнод аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөрийн хэлтсээс хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд зарцуулсан төсвийн үр ашгийг хэрхэн тооцсон нь тодорхойгүй байна. Сургалт, зөвлөгөө, мэдээлэлд хамрагдсан иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ болон бусад арга хэмжээнд хамрагдсан байдлаар авч үзвэл дунджаар нь 51.3 хувь нь хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамрагдсан байна.

Хүснэгт 7. “Нийтлэг үйлчилгээнд хамрагдсан иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамрагдсан хувь”

	2016	2017	2018	2019	2020	2021	Дундаж
Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн хувь	76.7	42.0	60.2	62.2	32.7	34.5	51.3

Эх сурвалж: ХХҮГ-ын 2016-2021 оны үйл ажиллагааны тайлан

Хөдөлмөрийн хэлтсийн 2016-2021 оны тайлангуудаас үзэхэд сургалт, зөвлөгөөнд иргэдийн хамруулж, ажлын байранд зуучлаад байгаа ч Дорнод аймаг ядуурлын хамралтын хүрээгээрээ улсын дундаж функтээс 10.7- 14.1 өндөр байна. Харин 2020 онд өмнөх үеэс буурсан үзүүлэлттэй гарсан байна.

Хүснэгт 8. “Ядуурлын хамралтын хүрээ”

	2016	2018	2020
Улсын дүн	29.6	28.4	27.8
Дорнод	41.5	42.5	37.1

Эх сурвалж: www.1212.mn

Дээрх шинжилгээнүүдийн дүнд нийтлэг үйлчилгээнд хамрагдсан иргэд нь хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг бүрэн авч чадахгүй, ядуурлын хамралтын хүрээгээр улсын дунджаас өндөр байгаа зэрэг үзүүлэлтүүд нь нийтлэг үйлчилгээний үр дүн харагдахгүй байгааг харуулж байна.

5. Орон нутагт нийтийг хамарсан ажил, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар хэрэгжүүлсэн арга хэмжээ үр нөлөөгүй байна.

5.1. Гадаадын санхүүжилттэй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт үр дүнтэй байна.

Дорнод аймагт Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, чиглэлээр 2016-2021 онд Европын холбооны санхүүжилттэй хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, иргэдийн хэрэгцээнд тулгуурлан “Монгол Улсад ажлын байрыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх Secim төсөл”, Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүжилттэй “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”, Дэлхийн банкны санхүүжилттэй “Хөдөлмөр эрхлэлтийн туршилтын хөтөлбөр” гэсэн төсөл, хөтөлбөрүүд тус тус хэрэгжсэн байна.

“Secim төсөл”-ийн хүрээнд 2021 онд 5.3 сая төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж ХХҮГ-т ажил олгогч болон ажил хайгч иргэдэд зориулсан ганцаарчилсан зөвлөгөө өгөх өрөөг нээн тохижуулснаар зөвлөгөө өгөх орчин нөхцөл бүрдсэн, аймгийн

хөдөлмөрийн зах зээлд тохирсон идэвхтэй бодлогыг тодорхойлох, ажил олгогчид, ажил хайгч иргэдийн мэдээллийн хэрэгцээнд нийлүүлэх зорилгоор “Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгаа”-г хийсэн байна. Төсөл хэрэгжсэнээр нийт 5180 иргэн сургалтад, зорилтот бүлгийн 185 иргэн байнгын ажлын байртай болж хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн санд бүртгэгдсэн байна.

“Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-ийн хүрээнд “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний загвар төв”-ийг байгуулж тохижуулсан бөгөөд үүний үр дүнд асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхжуулах зорилгоор шат дараалсан сургалтуудад хамруулж, орон нутгийн залуучуудын хамтын ажиллагааг дэмжих үйлчилгээ, ажил хайгчийн хөдөлмөрлөх чадварт үнэлгээ хийх үйлчилгээ, ажил хайгчийн хөдөлмөр эрхлэлтийн хувийн төлөвлөгөө боловсруулах үйлчилгээ үзүүлэх арга зүйгээр хангагдсан байна. Мөн шинээр ажилд орж буй иргэдийг дагалдуулан сургах Интерншип хөтөлбөрийн хүрээнд 7 байгууллагад 33 иргэн байнгын ажлын байртай болж хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн санд бүртгэгдсэн байна.

“Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөр”-ийн хөрөнгөөр бичил бизнес эрхлэгчдийг жижиг зээлийн өмнөх болон дараах сургалт, орон нутгийн санаачилгын төсөл гэсэн 2 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 2020 онд 53.3 сая төгрөгөөр, 2021 онд 42.7 сая төгрөгөөр санхүүжүүлсэн байна. Санхүүгийн бус дэмжлэгийн хувьд банкаар дамжуулж иргэдэд жижиг зээл, зээлийн өмнөх болон дараах сургалтад нийт 294 иргэнийг хамруулж, 18.8 сая төгрөгийг, орон нутгийн санаачилгын төсөлд 60 иргэнийг хамруулж, 77.2 сая төгрөгийг сургалтын үйл ажиллагаанд зарцуулсан байна. Тус төслийн хөрөнгөөр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд зарцуулснаар албан бус салбарт хөдөлмөр эрхэлж буй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлын хүрээнд мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж мэргэжил болон мэргэжлийн зэрэг дэв олгох, ажлын байрны тогтвортой байдлыг ханган бүтээмжийг нэмэгдүүлэх замаар албан салбарт шилжүүлэхэд дэмжлэг болсон байна.

Дээрх нөхцөл байдлаас үзэхэд гадаадын санхүүжилттэй төсөл, хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлсэн гэж үзэж байна.

5.2. Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг бодитой үнэлж ажиллаагүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т заасан хэлбэрээр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг зохион байгуулж ажилладаг байна. Үүнд

1. Хөдөлмөрт бэлтгэх
2. Хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах
3. Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийг дэмжих, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих
4. Ажил олгогчийг дэмжих
5. Нийтийг хамарсан ажил зохион байгуулах
6. Ажил олоход хүндрэлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих
7. Хууль тогтоомжид заасан, түүнчлэн Засгийн газрын болон Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн шийдвэрээр тодорхойлсон бусад төсөл, хөтөлбөр

Аймгийн ХХҮГ-аас хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн үр дүнг аймгийн ажилгүйдэл, ядуурлын түвшинтэй харьцуулж, бодитой үнэлж, дүгнэхгүй байна. Өөрөөр хэлбэл төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнгийн хэрэгжилтийг өмнөх оны төсөл, хөтөлбөрийн биелэлттэй харьцуулж байгаа нь учир дутагдалтай байна.

Дорнод аймгийн ХХҮГ-ын төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд ХХҮЕГ-аас дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тухай тайлан, дүгнэлт байхгүй байна.

Энэ нь Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлогын 6.3-т “Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг жил бүр, хөндлөнгийн үнэлгээг 5 жил тутам тус тус хийж дүнг Засгийн газарт тайлагнана.” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 32.2 дахь заалт, ЗГ-ын 2011 оны 375 дугаар тогтоолоор батлагдсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 5.4-т “Сангийн үйл ажиллагаанд мэргэжлсэн байгууллагаар хөндлөнгийн үнэлгээ хийлгэж, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлд жил бүр танилцуулна.” гэсэн заалтууд хэрэгжээгүй, хөндлөнгийн үнэлгээ 2016-2021 онд хийгдээгүй байна.

Дорнод аймгийн ХХҮГ-аас Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагааны дотоод хяналтыг 2016-2022 оны үйл ажиллагааны хүрээнд хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр жил бүр эрсдэлийн төлөвлөгөөг батлуулж, дотоод хяналтыг хийж, зээлийн хугацаа хэтэрсэн иргэн, аж ахуйн нэгжүүдийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн ажилласан байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 32.1.1 болон 32.1.2 дахь заалт мөн журмын 5.3 дахь заалтын хүрээнд Дорнод аймгийн Санхүүгийн хяналт, аудитын газар болон Мэргэжлийн хяналтын газруудаас ХЭДС-гийн хөрөнгийн зарцуулалтад хяналт шалгалт хийгдсэн боловч хэрэгжилтийн тайланг аудитын хугацаанд ирүүлээгүй болно.

Төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг үзэхдээ нийтийг хамарсан ажилд оролцсон иргэдээс түүвэрлэн авч 2018-2021 оны дансны хуулганд тулган баталгаажуулалт хийхэд аймгийн төрийн байгууллагуудын зарим албан тушаалтнуудын арилжааны банкны хувийн харилцах данс руу дамжин орсон, мөн нийтийг хамарсан үйлчилгээнд хамрагдсан иргэдийн данс хооронд ажлын хөлсийг гүйлгэн шилжүүлсэн тохиолдлуудыг хууль, хяналтын байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэв.

Нийтийг хамарсан ажилд тайлант хугацаанд жилдээ 71.5-172.5 сая төгрөгийг үр дүнгүй зарцуулсан байна. Өнгөрсөн 2021 онд “ковид-2019” цар тахлын улмаас хөл хориотой үед ч нийтийг хамарсан ажлыг зохион байгуулсаар ирсэн байна.

Хүснэгт 9. “Нийтийг хамарсан үйлчилгээнд хамрагдсан иргэний тоо, мөнгөн дүн сая.төгрөг”

Нийтийг хамарсан ажилд хамрагдсан иргэн, мөнгөн дүн	2016		2017		2018		2019		2020		2021	
	Иргэн	Мөнгөн дүн	Иргэн	Мөнгөн дүн	Иргэн	Мөнгөн дүн	Иргэн	Мөнгөн дүн	Иргэн	Мөнгөн дүн	Иргэн	Мөнгөн дүн
	545	100.1	688	172.5	394	86.8	409	87.7	326	92.6	303	71.5

Эх сурвалж: ХХҮГ-ын санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан

Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөрийн хүрээнд тайлант хугацаанд дараах сургалтыг хийсэн байна. Сургалтууд нь 2016 онд 39.8 хувь, 2019 онд 71.3 хувийн биелэлттэй зорилтот түвшиндээ хүрээгүй байна. /Хавсралтаар сургалтын задаргааг харуулав./

Хүснэгт 10. “ХЭДС-аар хэрэгжсэн хөтөлбөр, төслийн хэрэгжилт сая.төг”

№	Хөтөлбөр, арга хэмжээний нэрс	2016		2017		2018		2019		2020		2021		Нийт дүн 2016-2021	
		Хүн	Хөрөнгө	Хүн	Хөрөнгө	Хүн	Хөрөнгө	Хүн	Хөрөнгө	Хүн	Хөрөнгө	Хүн	Хөрөнгө	Хүн	Хөрөнгө
1	Гүйцэтгэлийн хувь		74.5		96.05		90.3		98.9		56.6		54.9		80.2
2	ХЭДС-гийн батлагдсан төсөв	3,965	1,025.0	3,633	1,316.4	4,065	1,544.9	6,258	1,356.9	2,515	1,277.8	5,910	1,267.7	26,346	7,788.9
3	Зарцуулалт нийт дүн	3,095	763.8	3,948	1,188.9	4,969.0	1,533.2	7,035	1,341.9	4,060	723.0	4,819	695.6	27,926	6,246.5
Хөтөлбөр, төсөл арга хэмжээ															
1	Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ	1,151	13.5	1,159	9.3	1,671	13.6	3,705	25.6	2,050	15.6	2,479	15.6	12,215	93.2
2	Ажилд зуучлах үйлчилгээ	763	1.3	1,050	12.3	1,561	10.7	1,571	11.1	1,087	9.6	1,254	6.6	7,286	51.6
3	Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр	45	24.7	271	31.6	236	34.1	243	34.1	122	14.3	469	29.4	1,386	168.2
4	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	350	176.1	781	451.6	920	451.3	810	532.3	511	365.5	180	314.3	3,552	2,291.2
5	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр	24	22.7	101	106.6	102	97.5	131	210.4	43	16.9	262	41.6	663	495.8
6	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	67	270.9	186	319.4	171	300.7	366	300.5	131	132.5	42	74.6	963	1,398.8
7	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	102	58.5	174	110.3	132	72.3	137	78.3	69	92.1	91	112.1	705	523.7
8	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр	43	8.6	79	54.4	83	31.2	70	39.9	46	14.7	41	45.6	362	194.5
9	Үйл ажиллагааны зардал		32.6		90.1	20	33.3		105.1		57.5		38.6	20	357.2
10	Бусад хөтөлбөр төсөл		52.7			70	35.7						17.0	70	105.5
11	НХА	545	100.1											545	100.1
12	Хүүхэд хамгаалал		0.9	144	2.9		2.5	2	4.5		3.9			146	14.8
13	Хүүгийн хөнгөлөлт	5	0.9	3	0.3	3	0.2	-	-	1	122.2	1	0.2	13	1.7

Эх сурвалж: ХЭДС-ийн 2016-2021 оны гүйцэтгэлийн мэдээ 2022.03.16

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр ХХҮГ-аар дамжуулан хэрэгжсэн хөтөлбөр, төсөл арга хэмжээний хэрэгжилтийг санхүүжилттэй нь харьцуулж үзэхэд 2016-2021 онд батлагдсан төсвийг хөтөлбөр, төсөл арга хэмжээний зардалд 80.2 хувийн гүйцэтгэлтэй зарцуулсан байна.

5.3. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар тусгайлан авч хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй байна.

Засгийн газрын 2016 оны 320 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого”-ын 4.1.6-д “Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн зах зээл дэх тэгш оролцоог хангах, зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх” гэж заасны дагуу эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар тусгайлан авч хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр орон нутгийн хэмжээнд байхгүй байна.

Дорнод аймгийн хэмжээнд 2016-2021 оны байдлаар хөдөлмөр эрхлэх сонирхолтой ажил идэвхтэй хайгч иргэдийн 41.9-50.1 хувийг эмэгтэйчүүд эзэлж, хөдөлмөрт зуучлагдах байдал нь 35.2-45.9 хувьтай байна⁸. Үүнээс үзэхэд хөдөлмөрийн зах зээл дэх эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн оролцооны түвшин ялгаатай байна.

Харин АИТХ-ын тогтоолоор “Эмэгтэйчүүдийн хөгжил” хөтөлбөрийг 2014 оноос хойш боловсруулан баталж, хэрэгжүүлэн дүгнэж хэвшсэн байна.

- Энэхүү хөтөлбөрийн хүрээнд “Эмэгтэйчүүд ба хөдөлмөр эрхлэлт” буюу зорилт 3⁹ 2017-2020 онд хэрэгжсэнээр эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин 2016 онд 52.5 хувьтай бол 2019 оны байдлаар 45.5 хувьтай болж буурч, орон нутгийн хөгжилд хувь нэмрээ оруулж байгаа бизнесмен эмэгтэйчүүдийн тоо 2016 онтой харьцуулахад 2019 оны байдлаар 10.0 хувиар нэмэгдсэн талаар хэрэгжилтийн тайланд тусгасан байна. Уг хөтөлбөрт орон нутгийн төсвөөс 2017 онд 10.0 сая төгрөг, 2018-2020 онд тус бүр 7.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна¹⁰.

⁸ Аймгийн ХХҮГ-ын Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсээс гаргасан статистик мэдээнээс

⁹ Аймгийн ИТХТ-ийн долоодугаар хуралдааны тогтоол. №02, хэрэгжсэн хугацаа 2017.01.06-2020.11.30, Зорилт 3 буюу “Эмэгтэйчүүд ба хөдөлмөр эрхлэлт”-ийн биелэлт

¹⁰ ГБХЗХГ-ын 2017-2021 оны тайлан

Мөн “Эмэгтэйчүүдийн хөгжил”¹¹ хөтөлбөрийг 2021-2024 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр баталсан.

- Уг хөтөлбөрийн зорилт 2-т Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэл¹²-ээр 3 арга хэмжээг тусгаж, 2021 оны хэрэгжилтээр аймгийн ХХҮГ-тай хамтарч 10 эмэгтэйд 25.0 сая төгрөгийн дэмжлэгийг орон нутгийн төсвөөс үзүүлж, 120 эмэгтэй сургалтад хамрагдаж, 160 гаруй эмэгтэй байнгын болон түр ажлын байранд зуучлагдсан талаар хэрэгжилтийн тайланд тусгасан байна.

6. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан (ХЭДС)-гийн орлогын төлөвлөгөөг дунджаар 91.6 хувийг биелүүлж, 9.2 сая төгрөгийг хууль, журмын дагуу зарцуулаагүй байна.

6.1. ХЭДС-ийн орлогын төлөвлөгөө 2016-2021 онд дунджаар 91.6 хувийн биелэлттэй байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлогыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1¹³-д заасан эх үүсвэрээс бүрдэнэ гэж заажээ.

Дорнод аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангийн орлогын эх үүсвэр нь 2016-2021 онд хуульд заасан улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө, олон улсын байгууллагаас санд оруулсан хандив тусламж, хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх төлбөр, жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөгдсөн хөрөнгөөс бүрдсэн байна. Эдгээрээс хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулаагүйн төлбөрийн орлогыг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв санд төлөвлөгөөний дагуу 2016-2021 онд нийт 258.5 сая төгрөгийг бүрэн төвлөрүүлсэн байна.

Сан нь 2016-2021 онд нийт 7,836.3 сая төгрөгийн орлогын төлөвлөгөөнөөс гүйцэтгэлээр 7,179.7 сая төгрөг орж, 91.6 хувьтай биелсэн байна.

Сангийн 2016-2021 онуудын нийт орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 11. “ХЭДС-ийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл 2016-2021 он, сая.төгрөг”

Д/ д	Он	Орлого						Биелэлт /хувиар/
		Төлөвлөгөө			Гүйцэтгэл			
		Улсын төсвийн болон гадаадын санхүүжилт	ХБИ ажиллуул- аагүйн төлбөр	Дүн	Улсын төсвийн болон гадаадын санхүүжилт	ХБИ ажиллуул- аагүйн төлбөр	Дүн	
1	2016	1,025.0	10.0	1,035.0	768.0	10.5	790.3	76.3
2	2017	1,316.4	-	1,316.4	1,264.4	-	1,264.4	96.0
3	2018	1,545.0	-	1,545.0	1,533.5	-	1,533.5	99.2
4	2019	1,348.9	8.0	1,356.9	1,339.5	10.4	1,349.9	99.5

¹¹ Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 87 дугаар тоот тогтоолоор батлагдсан, Хөтөлбөр хэрэгжих хугацаа: 2021-2024 он.

¹²1. Хувиараа хөдөлмөр эрхлэхэд нь санхүүгийн дэмжлэг үзүүлэх бичил төслүүдийг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх, үйл ажиллагаагаа эрхлэхэд шаардагдах ур чадварыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, холбон зуучлах

2. Гэртээ хүүхдээ асардаг, гэрийн хөдөлмөр эрхэлдэг эмэгтэйг өөрсдийн ур чадвар, сонирхол, чадварт тулгуурласан гэрээрээ орлого олох, бизнес эрхлэх боломжийг дэмжих/сургалт, тоног төхөөрөмжийн дэмжлэг/

3. Зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд тулгамдаж буй бэрхшээлийг тодорхойлж тэднийг чадавхжуулахад анхаарах /Өрх толгойлсон, хөгжлийн бэрхшээлтэй гэх мэт/ гэсэн заалтуудыг тусгасан байна.

¹³ 22.1.1.улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө; 22.1.2.орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө; 22.1.3.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн чөлөөт үлдэгдлийг банкинд хадгалуулсны хүү; 22.1.4.гадаадын иргэнийг гэрээгээр ажиллуулсан ажил олгогчийн төлөх ажлын байрны төлбөр; 22.1.5.гадаад улс, олон улсын байгууллагаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор олгосон зээл; 22.1.6.гадаад улс, олон улсын байгууллага, Монгол Улсын болон гадаад улсын аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллага, иргэдээс Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд оруулсан хандив, тусламж; 22.1.7.хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх төлбөр; 22.1.8.жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөгдсөн хөрөнгө; 22.1.9.бусад эх үүсвэр.

5	2020	1,277.8	8.0	1,285.8	777.6	125.0	902.6	70.2
6	2021	1,289.2	8.0	1,297.2	1,238.2	112.6	1,350.8	104.1
	Нийт дүн	7,802.3	34.0	7,836.3	6,921.2	258.5	7,179.7	91.6

Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан

Хүснэгтээс үзэхэд ХБИ ажиллуулаагүйн төлбөрийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг бүрэн хангаж ажилласан байна. Харин санхүүжилтийг 2016 болон 2020 онд бүрэн аваагүй шалтгаан нь 2016 онд бүтцийн өөрчлөлттэй холбоотой тухайн оны санхүүжилтийг зогсоосон, 2020 онд “ковид” цар тахалтай холбоотой санхүүжилтийн хуваарьт өөрчлөлт орж, өр төлбөр үүссэн байна.

Сангийн орлогын эх үүсвэр болох эргэн төлөгдөх нөхцөлтэй жижиг зээл, санхүүгийн дэмжлэгээс 2016-2021 онд нийт 1,541.5 сая төгрөгийг хөдөлмөр эрхлэлтийн дэмжих төв санд төвлөрүүлсэн боловч 2021 оны жилийн эцсийн байдлаар авлагын нийт 2,159.8 сая төгрөгийн үлдэгдлийн 164.2 сая төгрөг буюу 7.6 хувь нь хугацаа хэтэрсэн авлага байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах ажлын зохион байгуулах талаар 1 зөвлөмж өгсөн байна.

6.2. ХЭДС-ийн хөрөнгийн 9.2 сая төгрөгийг хууль, журмын дагуу зарцуулаагүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1¹⁴-д заасан үйл ажиллагаанд зарцуулахаар заажээ.

Сан нь аудитын хамрах хүрээний 2016-2021 онд нийт 7,807.8 сая төгрөгийн зардлын төлөвлөгөөнөөс гүйцэтгэлээр 6,894.9 сая төгрөгийн зардал гаргасан байна.

Сангийн 2016-2021 оны төсөвт зардлын гүйцэтгэлийг үйл ажиллагааны төрлөөр нь хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 12. “ХЭДС-ийн зардлын гүйцэтгэл 2016-2021 он, сая төгрөг”

№	Он	Зардал		Зөрүү	Биелэлт /хувиар/
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	2016	1,025.0	763.9	261.1	74.5
2	2017	1,316.4	1,241.4	75.0	94.3
3	2018	1,545.0	1,533.3	11.7	99.2
4	2019	1,346.4	1,341.8	4.6	99.6
5	2020	1,277.8	776.3	501.5	60.7
6	2021	1,297.2	1,238.2	59.0	95.4
	Нийт дүн	7,807.8	6,894.9	912.9	88.3

Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан

¹⁴ 23.1.1.ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах; 23.1.2.ажилд зуучлах; 23.1.3.хөдөлмөрт бэлтгэх; 23.1.4.хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах; 23.1.5.ажил олгогчийг дэмжих; 23.1.6.нийтийг хамарсан ажил зохион байгуулах; 23.1.7.малчин, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих; 23.1.8.ажил олоход хүндрэлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих; 23.1.9.хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн сүлжээг бүрдүүлэх, ажиллуулах, шинэчлэх;

Дүрслэл 5. “ХЭДС-ийн 2016-2021 оны төсвийн гүйцэтгэл дэх нийт зардлын харьцаа”



Эх сурвалж: ХХҮГ-ын 2016-2022 оны төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан

Графикаас харахад нийт зардлын 4,132.9 сая төгрөг буюу 60.0 хувийг малчин, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих, 885.7 сая төгрөг буюу 12.8 хувийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа, 608.0 сая төгрөг буюу 8.8 хувийг нийтийг хамарсан ажил зохион байгуулах, 291.9 сая төгрөг буюу 4.2 хувийг ажил олгогчийг дэмжих, 268.8 сая төгрөг буюу 3.9 хувийг ажил олоход хүндрэлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, 707.6 сая төгрөг буюу 10.3 хувийг бусад арга хэмжээний зардлууд тус тус эзэлж байна.

Аудитын явцад сангийн хөрөнгийг хууль журмын дагуу зарцуулсан эсэхийг өндөр дүнтэй мөнгөн гүйлгээнээс түүврийн сорилыг гүйцэтгэхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:


- Дорнод аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт зохион байгуулсан сургалтад тус газрын 3 албан хаагчийн томилолтын зардалд 0.4 сая төгрөгийг зарцуулсан байна.
- Сан нь 2019 онд үйлдвэрлэл дээрх сургалт зохион байгуулах гэрээг “Хайртбүрд” ХХК-тай байгуулж, сургалтын төлбөрт 5.7 сая төгрөгийг төлсөн боловч анхан шатны баримт байхгүй байна.
- Урсгал зардлаас 2019 онд 3.1 сая төгрөгөөр үндсэн хөрөнгө /компьютер, принтер/ худалдан авахад зарцуулсан байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.3-д “Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

7. Мэргэжлийн боловсрол сургалтыг дэмжих сан (МБСДС) болон Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагаас хөдөлмөрт бэлтгэх үйл ажиллагаа үр нөлөө багатай байна.

7.1. Орон нутгийн хэмжээнд МБСДС-ийн хөрөнгийг үр ашигтай, үр дүнтэй ашиглаж, нөлөөллийг үнэлэх үйл ажиллагаа хангалтгүй байна.

Дүрслэл 6. “Суралцагчийн тоо болон суралцагчид сард олгох тэтгэлгийн хэмжээний өөрчлөлтийн хоорондын хамаарал”



Эх сурвалж: Дорнод аймаг дахь МСҮТ, Политехник коллежийн 2016-2021 оны тайлангаас

Орон нутгийн МБС-ын байгууллагын суралцагчийн тоо 2016 онд 1250 байсан бол 2021 онд 1233 болж 1.4 хувиар буурсан байна. Энэ хугацаанд төсвийн санхүүжилт 1,419.0 сая төгрөгөөс 1,825.0 сая төгрөгт хүрсэн буюу 28.6 хувиар өссөн байна. Эндээс үзэхэд МБС-ын байгууллагууд санхүү, төсвийн үр ашиг багатай ажиллаж байна гэж дүгнэж болохоор байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.2-т “өмчийн хэлбэр харгалзахгүйгээр мэргэжлийн өөрийн өртгийг үндэслэн тогтоосон нэг сурагчид ногдох хувьсах зардлаар олгосон санхүүжилт, тэтгэлэг,” гэж тусгаж, Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 94 дүгээр тогтоолоор “Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив”-д зааснаар Дорнод аймгийн МБС-ын байгууллагын 1 суралцагчид ногдох хувьсах зардлын нормативыг 593.8 мянган төгрөгөөр тогтоосон байна.

- Нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативыг мөрдүүлэхээр Засгийн газраас баталсан ч төрийн өмчийн мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төсвийг хувьсах зардлаар тооцолгүйгээр шууд улсын төсвөөс санхүүжүүлж байгаа нь норматив зардлын ач холбогдлыг бууруулж байна.¹⁵ Дорнод аймгийн хувьд МБСБ-ууд адил ба сүүлийн жилүүдэд суралцагчдын тооноос үл хамааран хувьсах зардал буурч санхүүжигдсэн байна.

Төсвийн санхүүжилтийн үзүүлэлтээс гадна төлөвлөлт, гүйцэтгэлийн “орц” болон “гарц”-ын үзүүлэлтүүд хоорондын хамааралд шинжилгээ хийх нь чухал ач холбогдолтой юм. Тухайлбал,

- Дорнод аймаг дахь МСҮТ-ийн хувьд 2016-2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт дунджаар 10 зорилт(хөтөлбөр)-ын хүрээнд 47 төлөвлөсөн арга хэмжээнээс 41 арга хэмжээ бүрэн хэрэгжсэнээр 82.4 хувьтай үнэлэгдэж дүгнэгдсэн байна.
- Харин Дорнод аймаг дахь Политехник коллежийн хувьд 2016-2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт дунджаар 10 зорилт(хөтөлбөр)-ын хүрээнд 52 төлөвлөсөн арга хэмжээнээс 50 арга хэмжээ бүрэн хэрэгжсэнээр 91.1 хувьтай үнэлэгдэж дүгнэгдсэн байна.

¹⁵ “Монгол Улсын МБС-ын санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгох нь”, ТХЗ-той уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь төсөл, 2021 он

Зорилтын хүрээнд төлөвлөгдсөн арга хэмжээнүүд хийгдэж байгаа ч гарч буй үр дүнгээс шалтгаалж үнэлгээний хувь буурсан байна.

Хүснэгт 13. “Дорнод аймгийн МБСБ-уудын 2016-2021 оны санхүүгийн тайлангийн шинжилгээ(хувиар)”

Ангилал	МСҮТ					Политехник коллеж				
	2017 2016	2018 2017	2019 2018	2020 2019	2021 2020	2017 2016	2018 2017	2019 2018	2020 2019	2021 2020
НИЙТ ЗАРЛАГ ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	96.7	103.0	139.5	114.3	97.6	103.6	98.5	120.5	115.9	95.4
УРСГАЛ ЗАРДАЛ	96.7	103.0	139.5	114.3	97.6	103.6	98.5	120.5	115.9	95.4
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	100.1	105.5	129.6	119.1	92.4	101.1	103.2	120.9	109.5	97.9
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	99.0	104.5	137.0	120.9	100.0	99.0	102.6	131.7	116.9	99.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	99.0	114.0	142.7	130.6	100.0	99.0	111.9	137.2	126.2	99.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	139.2	113.3	98.5	121.4	59.8	100.5	100.1	86.5	98.3	101.5
Хангамж, бараа материалын зардал	102.8	111.8	92.2	105.3	175.5	106.1	111.1	100.0	237.4	79.0
Нормативт зардал	122.3	101.2	129.5	114.7	57.4	109.7	108.5	90.6	71.8	49.3
Эд хогшил, урсгал засварын зардал	53.4	149.1	188.9	35.5	7.0	177.7	100.0	311.1	60.2	112.4
Томилолт, зочны зардал	118.4	100.0	100.0	100.0	6.0	118.4	100.0	100.0	16.4	80.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	73.2	148.6	85.6	117.3	54.3	87.7	104.7	100.0	100.5	105.1
Бараа үйлчилгээний бусад зардал	73.0	91.6	116.8	100.0	60.2	116.5	100.0	107.4	58.5	98.9
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	57.4	51.9	543.1	67.8	186.4	144.3	45.8	111.4	293.7	70.4
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	96.7	103.0	139.5	114.3	97.6	103.6	98.5	120.5	115.9	95.4
Улсын төсвөөс санхүүжих	95.2	104.4	140.0	114.5	97.6	102.7	98.5	120.2	116.5	95.3
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас санхүүжих	226.7	5.0	100.0	100.0	100.0	142.6	100.0	130.6	100.0	100.0

Эх сурвалж: Дорнод аймаг дахь МСҮТ, Политехник коллежийн 2016-2021 оны аудитлагдсан санхүүгийн тайлангаас

7.2. Орон нутагт МБС-ын байгууллагын санхүүжилт үр нөлөө багатай байна.

Сүүлийн 6 жилийн статистикаас харахад, МБСБ-ын санхүүжилт нь улсын төсвөөс 96.5-99.2%-ийн хамааралтай байгаа бөгөөд үлдэх 0.8-3.5 хүртэлх хувийг үндсэн ба туслах үйл ажиллагааны орлогуудаас бүрдүүлж байна.

Хүснэгт 14. “МБС-ын байгууллагын орлогын бүтцийн шинжилгээ (хувиар)”

Тайлант хугацаа	МСҮТ						Политехник коллеж					
	2016	2017	2018	2019	2020	2021	2016	2017	2018	2019	2020	2021
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Улсын төсвөөс санхүүжих	98.9	97.4	98.8	99.1	99.2	99.2	97.8	96.7	96.8	96.5	97.0	96.8
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	1.1	2.6	1.2	0.9	0.8	0.8	2.2	3.3	3.2	3.5	3.0	3.2
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1.1	2.6	1.2	0.9	0.8	0.8	1.8	2.7	2.6	3.0	2.6	2.7
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих							0.4	0.7	0.6	0.5	0.5	0.5

Эх сурвалж: Дорнод аймаг дахь МСҮТ, Политехник коллежийн 2016-2021 оны аудитлагдсан санхүүгийн тайлангаас

Хүснэгт 15. “МБС-ын байгууллагын зардлын бүтцийн шинжилгээ (хувиар)”

Тайлант хугацаа	МСҮТ						Политехник коллеж					
	2016	2017	2018	2019	2020	2021	2016	2017	2018	2019	2020	2021
УРСГАЛ ЗАРДАЛ	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Бараа үйлчилгээний зардал	92.0	95.3	97.6	90.7	94.5	89.5	94.2	91.9	96.2	96.5	91.2	93.5
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	60.7	62.2	63.1	61.9	65.5	67.1	58.2	55.6	57.9	63.2	63.8	66.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6.7	6.8	7.6	7.7	8.8	9.1	6.4	6.1	6.9	7.9	8.6	9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7.9	11.3	12.5	8.8	9.3	5.7	13.4	13	13.2	9.4	8	8.5


Хангамж, бараа материалын зардал	1.8	1.9	2	1.3	1.2	2.2	1	1	1.2	1.0	2	1.7
Нормативт зардал	3.1	3.9	3.9	3.6	3.6	2.1	6.3	6.7	7.4	5.5	3.4	1.8
Эд хогшил, урсгал засварын зардал	0.7	0.4	0.6	0.8	0.3	0	0.3	0.6	0.6	1.5	0.8	0.9
Томилолт, зочны зардал	0.6	0.8	0.74	0.53	0.46	0.03	0.3	0.4	0.4	0.3	0.04	0.04
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.4	0.3	0.5	0.3	0.3	0.2	2.6	2.2	2.3	1.9	1.7	1.8
Бараа үйлчилгээний бусад зардал	10.1	7.6	6.8	5.7	5	3.1	5.7	6.4	6.5	5.8	2.9	3
Урсгал шилжүүлэг	8.0	4.7	2.4	9.3	5.5	10.5	5.8	8.1	3.8	3.5	8.8	6.5

Эх сурвалж: Дорнод аймаг дахь МСҮТ, Политехник коллежийн 2016-2021 оны аудитлагдсан санхүүгийн тайлангаас

МБС-ын санхүүжилт нь сургалтын үйл ажиллагаанд шаардагдах урсгал зардлыг санхүүжүүлэхэд зориулагдаж байна. Мөн салбарын санхүүжилт, хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй мэргэжилтэн бэлтгэх зорилготой уялдсаныг дүгнэн харах боломжгүй байна.

МБСБ нь ирэх жилийн төсвөө өмнөх үеийн зардлын гүйцэтгэлд суурилан өссөн дүнгийн аргаар боловсруулж, тухайлбал, МБСБ-ын түвшинд төсвийн төлөвлөлтийг зардлын төрлөөр боловсруулж, төсвийн үр ашиг, үр дүнг тодорхойлж байна.


Дүрслэл 7. "Дорнод аймаг дахь МСҮТ-ийн төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн хувь"



Эх сурвалж: Дорнод аймаг дахь МСҮТ-ийн статистик судалгаа

Дорнод аймаг дахь МСҮТ-ийн 2016-2021 оны төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн хувь өндөр байгаа нь 1 жилийн мэргэжлийн ангийн төгсөгчид нийт төгсөгчдийн 71.0 хувийг эзэлж байгаатай холбоотой ба 2019 онд хамгийн олон төгсөгчдийг бэлтгэн хөдөлмөрийн зах зээлд гаргасан байна. Хөдөлмөр эрхлэлтэд 2016-2021 онд нийт төгсөгчдөөс мэргэжлээрээ 40.5 хувь, мэргэжлийн бус 19.2 хувь, хувиараа хөдөлмөр эрхлэлт 24.9 хувь, дэвшин суралцаж байгаа 5.5 хувь тус тус байна. Ажил эрхлээгүй төгсөгчид 9.9 хувь байна.

Дүрслэл 8. "Дорнод аймаг дахь Политехник Коллежийн төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн хувь"




Эх сурвалж: Дорнод аймаг дахь Политехник Коллежийн статистик судалгаа

Дорнод аймаг дахь Политехник коллежийн хувьд 2016-2021 онд нийт төгсөгчдийн 50.6-68.4 хувь нь хөдөлмөр эрхэлж байгаагаас мэргэжлээрээ 30.8 хувь, мэргэжлийн бус 19.4 хувь, хувиараа хөдөлмөр эрхлэлт 18.1 хувь, дэвшин суралцаж байгаа 12.1 хувь тус тус байна. Ажил эрхлээгүй төгсөгчид 19.5 хувь байна.

Дорнод аймгийн хэмжээнд Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагаас 2016-2021 оны хооронд нийт 3047 суралцагч төгссөнөөс хөдөлмөр эрхлэлтийн хувьд мэргэжлээрээ 34.1 хувь, мэргэжлийн бус 19.3 хувь, хувиараа 20.4 хувь, дэвшин суралцаж буй 9.9 хувь, ажил эрхлээгүй 16.3 хувь тус тус байна.

Дорнод аймгийн МБС-ын байгууллагад 2016-2021 онд төсвөөс олгосон санхүүжилтийн хэмжээ болон ажлын байраар хангагдсан төгсөгчдийн тоо хоорондын хамаарлын коэффициент -0.66 буюу урвуу хамааралтай байгаа нь төсвийн санхүүжилтийн үр дүн, үр ашиг хангалтгүй байгааг илтгэж байна. Өөрөөр хэлбэл, төсвийн санхүүжилт нэмэгдсэн ч ажлын байраар хангагдсан төгсөгчдийн тоо буурсан нь МБС-ын үр дүн хангалтгүй, санхүүжилт үр ашгаа өгөхгүй байгааг харуулж байна. (Дүрслэл 5)

Дүрслэл 9. "Төсвийн санхүүжилт болон ажлын байртай болсон төгсөгчийн тоо хоорондын хамаарал (сая төгрөг)"



Эх сурвалж: Дорнод аймаг дахь МСҮТ, Политехник коллежийн 2016-2021 оны тайлангаас

8. "Ковид-19" цар тахлын үед хөдөлмөр эрхлэлтийн талаар төрөөс авч хэрэгжүүлсэн арга хэмжээ үр дүнтэй байна.

8.1. Цар тахлын үед ажлын байрыг хадгалах талаар Засгийн газраас гаргасан тогтоол шийдвэрийн үр дүнд 1102 аж ахуйн нэгж хөнгөлөлт, чөлөөлөлт, тэтгэмжид хамрагдсан ч зарим ААН-үүд ажлын байрны тоог бууруулсан байна.

Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5-д зааснаар Засгийн газар нь "Цар тахлын үед хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн улмаас үйл ажиллагаа нь доголдсон аж ахуйн нэгж, байгууллага, цалин, орлого нь тасалдсан иргэдэд зохих дэмжлэг үзүүлэх" гэж заасан байна. Тус зорилтын хүрээнд аймгийн Татварын хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтсээс аж ахуйн нэгжүүдийн орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэлд дараах хөнгөлөлт чөлөөлөлтийг үзүүлсэн байна.

1. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 21 дүгээр тогтоолоор цар тахлын улмаас үйл ажиллагаа нь доголдож, орлого нь буурч байгаа боловч ажлын байрыг хадгалж, хуульд заасан хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан ирүүлсэн 3.1.а.б.в.¹⁶-д зааснаас бусад хуулийн этгээдэд ажиллаж байгаа даатгуулагчийн 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд цар тахлын улмаас үйл ажиллагааны орлого буурч байгаа боловч ажлын байрыг хадгалж, хуульд заасан хугацаанд 2020-2021 онд тайлан ирүүлсэн 610 аж ахуйн нэгжид 9,669.4 сая төгрөгийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлсэн байна.
2. Цар тахалтай холбоотой үйл ажиллагаа нь доголдсон, түр зогссон, хаагдсан уул уурхайн компани, барилгын компани, худалдаа үйлчилгээний газар (баар, ресторан, хоолны газар, хүнсний худалдаа), төрийн байгууллага, хийд, барилгын компани, өрхийн эмнэлэг зэрэг нийт 93 ААНБ-ын 1825 иргэнд 365.0 сая төгрөгийн ажилгүйдлийн сангийн тэтгэмж олгосон байна.

¹⁶а/төрийн байгууллагад ажиллаж байгаа даатгуулагч;

б/төрийн өмчийн их, дээд сургуулиас бусад төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдэд ажиллаж байгаа даатгуулагч;

в/гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжаар бараа, ажил, үйлчилгээ гүйцэтгэсний төлбөрөөс цалин авч нийгмийн даатгалын шимтгэл нь төлөгдөх даатгуулагч.

Хүснэгт 16. “ААНБ-уудад ОАТ, НДШ-ийн хөнгөлөлт үзүүлсэн байдал”

№	Хөнгөлөлт, чөлөөлөлт, тэтгэмжийн төрөл	Иргэний тоо	ААН- ийн тоо	Хамарсан он		Дүн /сая.төг/
				2020	2021	
1	НДШ	-	610	7,772.7	1,896.7	9,669.4
2	Ажилгүйдлийн сангийн тэтгэмж	1825	93	365.0	-	365.0
3	ОАТ	-	399	1,125.4	-	1,125.4
Нийт		1825	1102	8,898.1	1,896.7	11,159.8

Эх сурвалж: “Аймгийн Татварын хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтсийн 2020-2021 оны тайлан, судалгаа”

3. Тогтоолын 3.2-д зааснаар аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 18.2¹⁷, 18.3¹⁸, 18.4¹⁹, 18.5²⁰-д заасан албан татвар ногдох орлогын нийт дүн нь өмнөх татварын жилд 1.5 тэрбум төгрөгөөс бага байсан төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдээс бусад Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан албан татвар төлөгчийн 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд нийт 399 аж ахуйн нэгжид 1,125.4 сая төгрөгийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлжээ.

УИХ-ын 2020 оны 21 дүгээр тогтоолын дагуу аймгийн хэмжээнд нийт 610 аж ахуйн нэгж, байгууллага нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдсанаас түүврийн аргаар 12 аж ахуйн нэгж, байгууллагын ажлын байраа хадгалж үлдсэн талаар судалгааг дараах байдлаар харуулав.

Хүснэгт 17. “Ажлын байрыг хадгалсан талаарх ААН-үүдийн судалгаа”

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Хугацаа /Он, сараар/			Хувь	
			2020.3	2021.3	2022.3	2021.3	2022.3
1	“Итгэл ивээлт” ХХК	Эрүүл мэнд	23	20	21	87.0	91.3
2	“Тод сүндрэл” ХХК	Барилга	27	37	43	137.0	159.3
3	Фловерь сургууль	Боловсрол	31	31	24	100.0	77.4
4	“ДТНДХ” ХХК	Тээвэр	39	27	24	69.2	61.5
5	“Алтай агро” ХХК	Хөдөө, аж ахуй	23	25	26	108.7	113.0
6	“Дорнод авто зам” ХХК	Зам засвар	24	27	28	112.5	116.7
7	“Адуунчулуун” ХХК	Уул уурхай	110	95	96	86.4	87.3
8	“Цагаансор” ХХК	Харуул хамгаалалт	48	51	54	106.3	112.5
9	“Талын чоно” ХХК	Машин засвар	2	2	2	100.0	100.0
10	“Ар тооромт уул” ХХК	Зоогийн газар	6	6	4	100.0	66.7
11	“Ганхэрлэн” ХХК	Зочид буудал	25	26	21	104.0	84.0
12	“Ханшувалдай” ХХК	Караоке, бар	12	8	8	66.7	66.7
Нийт дүн			370	355	351	98.1	94.7

Эх сурвалж: Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн судалгаа 2022.05.03

Цар тахлын үед /2020-2021 онд/ аж ахуй нэгжийн орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт, тэтгэмжид 1042 аж ахуйн нэгжүүд хамрагдсан байна. Үүнээс 12 аж ахуйн нэгж, байгууллагын хувьд 2021 оны 3 дугаар сарын байдлаар ажлын байраа хадгалсан байдал харилцан адилгүй буюу дунджаар 98.1 хувь, 2022 оны 3 дугаар сарын байдлаар 94.7 хувьтай байна. Гэвч 2021 онд

¹⁷ 18.2.Энэ хуулийн 8.1.1, 8.1.3, 8.1.4, 8.1.5, 9.1.1, 11.1.1, 11.1.4-т заасан албан татвар ногдох орлогын нийт дүнгээс энэ хуульд заасан зардлыг хасаж албан татвар ногдуулах орлогыг тодорхойлж, уг орлогоос энэ хуулийн 19 дүгээр зүйлд заасан шилжүүлэн тооцох алдагдлыг хасаж тухайн жилийн албан татвар ногдуулах орлогыг тодорхойлно.

¹⁸ 18.3.Хувьцаа, үнэт цаас, санхүүгийн бусад хэрэгсэл борлуулсан, шилжүүлсэн үнээс уг хувьцаа, үнэт цаасыг худалдаж авсан үнэ болон худалдан авахад төлсөн баримтаар нотлогдож байгаа шимтгэлийн дүнг хасаж, албан татвар ногдуулах орлогыг тодорхойлно.

¹⁹ 18.4.Энэ хуулийн 8.1.2-т заасан албан татвар ногдох орлогын нийт дүнгээс уг орлогыг олохтой холбогдон гарсан энэ хуулийн 13.1-д заасан нөхцөлийг хангасан зардал, хонжворт олгосон мөнгөн хөрөнгө болон барааны үнийг хасаж, албан татвар ногдуулах орлогыг тодорхойлно.

²⁰ 18.5.Энэ хуулийн 10.1.4-т заасан биет бус хөрөнгө болон хөдлөх эд хөрөнгө борлуулсан, шилжүүлсэн тохиолдолд албан татвар ногдуулах орлогыг уг хөрөнгийн борлуулсан, шилжүүлсэн орлогоос хөрөнгийн үлдэгдэл өртгийг хасаж тодорхойлно.

“Итгэл ивээлт” ХХК 87.0 хувь “ДТНДХ” ХХК 69.2 хувь, “Адуунчулуун” ХХК 86.4 хувь, “Ханшувалдай” ХХК 66.7 хувиар тус тус ажлын байрыг бууруулсан байна.

8.2. Цар тахлын үед орон нутагт ажилтныг дэмжих чиглэлээр авсан арга хэмжээ үр дүнтэй байна.

Цар тахлын үед ажилтныг дэмжих чиглэлээр Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.7 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын 2020 оны “Коронавируст халдвар /covid-19/-ын цар тахлын үед иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх багц арга хэмжээний тухай” тогтоол, ЗГ-ын 2021 оны 93, 122, 310 дугаар тогтоол, улс, аймгийн Онцгой комиссын тогтоол, шийдвэр, аймгийн Засаг даргын захирамжуудаар тус тус зохицуулагдсан байна. Үүнд:

1. Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.7²¹-д зааснаар иргэдийн ипотекийн зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийн үлдэгдэл хэмжээг 2020 оны 01 дүгээр сараас эхлэн хүсэлт гаргасан өдрөөс эхлэн 2022 оны 12 дугаар сарын 31-нийг хүртэл хугацаанд хойшлуулах,
2. Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 122 дугаар тогтоолоор айл өрх, зарим аж ахуйн нэгж, байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр, энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг 2020 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс тооцож 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд төрөөс хариуцан төлөх,
3. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 410 дугаар тогтоолоор орон сууцны айл өрхийн сард хэрэглэсэн 250 кВт.ц хүртэл, гэр хорооллын айл өрхийн сард хэрэглэсэн 350 кВт.ц хүртэл цахилгаан эрчим хүчний төлбөрийг 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2022 оны 5 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд төрөөс хариуцан төлөх,
4. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 93 дугаар тогтоолоор иргэдийг вакцинжуулах, тэдний орлого, дархлааг дэмжих зорилгоор Монгол Улсын иргэн бүрд 300,000 (гурван зуун мянга) төгрөгийн мөнгөн дэмжлэгийг нэг удаа олгох зэрэг шийдвэрүүд нь Монгол Улсын иргэн бүрд нэгэн адил хамааралтай үйлчилсэн байна.

Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/496, А/585 дугаар тушаалаар коронавируст халдварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээнд ажилласан эрүүл мэндийн салбарын ажилтнуудыг урамшуулах зорилгоор нэг удаа 814 ажилтанд 325.6 сая төгрөг, 903 ажилтанд 903.0 сая төгрөг, нийт 1,228.6 сая төгрөгийг 2020-2021 онд зарцуулсан байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/560, А/589 дүгээр захирамжаар коронавируст халдварын эрсдэлтэй нөхцөлд ажиллаж буй 110 албан хаагчид 20.0 сая төгрөг, 2021 оны А/365, А/366 дугаар захирамжаар коронавируст халдварын үед ажилласан 143 албан хаагчид 72.6 сая төгрөг, нийт 92.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

Улсын онцгой комисс, аймгийн онцгой комиссын тогтоол, аймгийн Засаг даргын захирамжаар дараах шийдвэрүүд хэрэгжсэн байна. Үүнд:

1. УОК-ын 2020 оны 6 дугаар тогтоолд цар тахлын хөл хориотой үед буюу 2020.03.11-2020.03.30 хүртэл жирэмсэн болон 0-12 насны хүүхэдтэй эмэгтэй ажилтан, албан хаагчийг гэрээсээ нийт байгууллагын хувьд жирэмсэн болон ын албан хаагчдыг гэрээсээ ажиллах нөхцөл боломжоор хангах, цалинтай чөлөө олгох,
2. АОК-ын 2021 оны 111 дүгээр тогтоолд байгууллагуудыг албан хаагчдынхаа ажиллах цагийн хуваарьт өөрчлөлт оруулж, 50 хүртэлх хувиар ажиллуулах, 50-иас дээш хувийг нь цахимаар ажиллуулах,

²¹ Төрөөс хэрэгжүүлж байгаа орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй хүүтэй зээлийн төлбөрийн үүргийн гүйцэтгэлийг зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийн үлдэгдэл хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр энэ хуулийн 18.1-д заасан хугацаа хүртэл хойшлуулах, мөн хугацаагаар зээлийн гэрээний хугацааг сунгах асуудлыг Засгийн газартай хамтран хэрэгжүүлнэ.

3. Аймгийн Засаг даргын 2020 оны А/160, А/540, 2021 оны 198, 206 дугаар захирамжаар гэрээсээ цахимаар ажиллаж байгаа албан хаагчид /0-12 насны хүүхэдтэй эх, ганц бие эцэг/, ковидоор өвдсөн ажилтан, албан хаагч, тусгаарлалтад байгаа ажилтан, өөр суманд дайчлагдан ажиллаж байгаа албан хаагчдад цалинтай чөлөө олгох шийдвэрүүдийг гаргаж, хэрэгжилтийг хангуулжээ.

Цар тахлын үед ажилтныг дэмжих чиглэлээр УИХ, ЗГ-ын шийдвэрүүдийг хэрэгжиж, ипотекийн зээлийг хойшлуулах, цахилгаан, цэвэр, бохир усны хэрэглээг төр хариуцах, вакцинжуулалтад хамрагдсан иргэдэд урамшуулал олгох шийдвэрүүд нь ажилтан, албан хаагчдын амьжиргааны түвшинд дэмжлэг болсон байна.

Мөн мэндийн салбар болон онцгой комиссын гишүүдэд урамшуулал олгож, бусад төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын албан хаагчдын ажиллах хэлбэр, ажлын цагийн хуваарьт зохицуулалт хийх, зайнаас ажиллуулах, цалинтай чөлөө олгох зэрэг шийдвэрүүд нь ажилтан, албан хаагчдын ажиллах нөхцөл, цалин, урамшуулалд дэмжлэг болсон байна.

8.3. Цар тахлын үеийн сөрөг нөлөөллөөс зорилтот бүлгийн хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг хамгаалах чиглэлээр хөтөлбөрүүд хэрэгжиж, 772 иргэн ажлын байраар хангагдсан байна.

Нийгмийн халамжийн тухай хуульд зааснаар зорилтот бүлэгт ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүнд нөхцөлд байгаа хүүхэд, хорих ангиас суллагдсан иргэн, 6 сараас дээш хугацаанд ажилгүй, ажил хайж байгаа иргэнийг хамааруулна.

Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 (арван) их наядын цогц төлөвлөгөө, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2020 оны 01 дүгээр тогтоолоор “Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр”, “Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр”, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-үүдэд зорилтот бүлгийн хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг хамгаалах чиглэлээр дараах зорилтууд тусгагдаж, хэрэгжсэн байна.

Хүснэгт 18. “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 (арван) их наядын цогц төлөвлөгөө, зорилтот бүлгийн хөдөлмөр эрхлэлтийн талаар хэрэгжүүлсэн хөтөлбөрийн хэрэгжилт”

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ, хөтөлбөр	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хэрэгжилт, үр дүн
Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 (арван) их наядын цогц төлөвлөгөө			
1	2.6. Залуучуудын хөгжил, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, хувь хүний хөгжлийн цогц сургалтын хөтөлбөр боловсруулан, залуучуудыг хамруулж хөдөлмөрт бэлтгэх, ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлэх	Засгийн газрын 2021 оны 58 дугаар тогтоолоор “Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төсөл”-ийг баталж, төсөлд Дорнод аймгаас 231 залуусыг бүртгэж, шалгаруулалтад оруулснаас 180 залуус тэнцэж сургалтад 87 иргэн хамрагдан 56 иргэн ажлын байртай болсон байна.	56 иргэн ажлын байртай болсон.
2	2.23. Хувиараа хөдөлмөр эрхлэх сонирхолтой ажилгүй, гэртээ хүүхэд асарч буй иргэн, хөдөлмөрийн насны халамж хүртэгчид өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхтэй холбоотой борлуулалтын болон ажлын байрны түрээсийн дэмжлэг үзүүлэх	Хүүгүй барьцаагүй, 100 хувийн эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгт 36 иргэний төслийг шалгаруулж, 170.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Жижиг дунд бизнес эрхлэгчдэд бараа бүтээгдэхүүнээ борлуулахад 3 иргэнд дэмжлэг үзүүлж, 3 дэлгүүрт борлуулалтын цэгийг байгуулсан байна. Ажил олоход хүндрэлтэй 15 иргэнийг байнгын ажлын байраар хангасан орон нутгийн 11 аж ахуй нэгжтэй гэрээний хэрэгжилтийг үндэслэн ажил олгогчийн урамшуулал болох 75.5 сая төгрөгийн урамшууллыг олгосон байна.	56 иргэн ажлын байраар хангагдсан байна.
3	2.24. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрт бэлтгэж ажлын байраар хангах, аж ахуй эрхлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх болон ажлын	Хөтөлбөрийн хүрээнд 40 иргэнийг аж ахуй эрхлэлтийн сургалтад хамруулж 1.6 сая төгрөг, эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт хамрагдах хүсэлтэй 24 иргэнийг сонгон шалгаруулж, ажил олоход хүндрэлтэй зорилтот бүлгийн 3 иргэнийг ажлын байраар хангасан 3 аж ахуйн	54 иргэнийг сургалтад хамруулж, 31 иргэнийг байнгын ажлын байраар

	байраар хангасан аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжиж, урамшуулах	нэгжид ажил олгогчийн урамшуулал олгож, цар тахлын үед тогтвортой хувиараа хөдөлмөр эрхлэн үйл ажиллагаа явуулж байгаа 7 иргэнийг түрээсийн хөнгөлөлтөд хамруулсан байна. Нийт 87 иргэнийг хамруулж 108.6 сая төгрөгийг зарцуулж, 14 иргэнийг түр сургалтад хамруулж, 27 иргэнийг байнгын ажлын байраар хангасан байна.	хангаж, 3 ААН-д урамшуулал олгосон байна.
ХЭҮЗ-өөс баталсан хөтөлбөрүүд			
1	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр	2020 онд ахмад настны зөвлөх үйлчилгээ болон санхүүгийн дэмжлэгт 34.6 сая төгрөгийг зарцуулж, 61 байнгын болон түр ажлын байр бий болгосон. 2021 онд тус хөтөлбөрийн хүрээнд 77 ахмад настныг зөвлөх үйлчилгээ, санхүүгийн дэмжлэгт 51 ахмадыг хамруулж, 45.6 сая төгрөгийг зарцуулж, 31 ахмадыг түр ажлын байр, 15 иргэнийг байнгын ажлын байраар хангасан байна.	107 ахмад настныг ажлын байраар хангасан байна.
2	Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр	Хөтөлбөрийн хүрээнд 8 төрлийн үйлчилгээ, арга хэмжээнд 24 байгууллага, аж ахуйн нэгж, 489 иргэнийг хамруулж, 252 түр, 65 байнгын ажлын байр тус тус шинээр бий болсон байна.	317 иргэн ажлын байраар хангагдсан байна.
3	Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр	2020 онд мэргэжлийн түр сургалт болон үйлдвэрийн сургалтад 122 иргэнийг хамруулж 14.7 сая төгрөг зарцуулж, 97 хүн байнгын болон түр ажлын байраар хангагдсан байна. 2021 онд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, сэтгэлзүйн зөвлөгөөнд 109 иргэнийг хамруулж 4.0 сая төгрөгийг зарцуулж, 85 иргэн байнгын ажлын байраар хангагдсан байна.	231 иргэнийг сургалтад хамруулж, 182 иргэнийг ажлын байранд зуучилсан байна.

Эх үүсвэр: ХХҮГ-ын 2020, 2021 оны үйл ажиллагааны тайлан, холбогдох хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан

Цар тахлын үед зорилтот бүлгийн хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг хамгаалах чиглэлээр “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 (арван) их наядын цогц төлөвлөгөө”, ХЭҮЗ-өөс баталсан залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд зориулсан хөтөлбөрүүдийн үр дүнд 772 иргэн ажлын байраар хангагдсан гэж тайлагнасан боловч аймгийн хэмжээнд ажилгүйдэл, ядуурлын түвшин улсын дунджаас дээгүүр байгаа нь зорилтот бүлэгт чиглэсэн арга хэмжээ бодит, үр дүнгээ өгөхгүй байгааг харуулж байна.

8.4. Цар тахлын улмаас хөдөлмөр эрхлэлтийн салбарт гарсан өөрчлөлт, статистик тоо мэдээг зөрүүтэй байдлаар гаргасан байна.

Статистикийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.16²², 16 дугаар зүйлийн 16.3²³, 18 дугаар зүйлийн 18.1²⁴-д Үндэсний статистикийн хороо, Статистикийн улсын байцаагч, бүх шатны Засаг даргын нийтлэг бүрэн эрхэд хамаарах мэдээллийн үнэн зөв, шуурхай, бодит байдлыг хангаж, тогтмол шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах талаар заасан байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д “Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан нь ажиллах хүчний талаарх мэдээ, мэдээлэл, ажлын байрны болон ажил хайгч, ажилгүй иргэн, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэн, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлэгч болон уг үйл ажиллагаанд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай холбогдсон бүртгэл, мэдээллийг агуулна.” гэж заасан байна.

Цар тахлын үед буюу 2019-2021 онд хөдөлмөр эрхлэлтийн өөрчлөлтийн статистик тоон мэдээллийг Үндэсний статистикийн хорооноос гаргасан байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоон үзүүлэлт нь www.1212.mn, www.Lmis.gov.mn сайтуудад зөрүүтэй байдлаар илэрхийлэгдсэн байна.

²² 16/хуулийн этгээдийн албан ёсны статистикийн мэдээллийн үнэн зөвийг шалгах, илэрсэн дутагдал, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах замаар статистикийн мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг хангах;

²³ 2/статистикийн мэдээллийн хамралт, үнэн зөв, шуурхай байдлыг шалгах;

²⁴ 1/албан ёсны статистик мэдээллийн үнэн зөв байдалд тогтмол шалгалт хийж, түүний бодит байдлыг хангах;

Хүснэгт 19. “Үндэсний статистикийн хороо, аймгийн ХХҮГ-аас гаргасан Дорнод аймгийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа 2019-2021 он”

№	Эх сурвалж	Хөдөлмөр эрхлэлтийн түвшин /Улирлаар/			Ажиллах хүчин /Улирлаар/			Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо /он, сараар/			Ажилгүйдлийн түвшин		
		2019.IV	2020.IV	2021.IV	2019.IV	2020.IV	2021.IV	2019.12	2020.12	2021.02	2019	2020	2021
1	Үндэсний статистикийн хороо	46.4	47.1	55.1	32,237	31,873	31,280	1,208	392	777	20.9	19.8	9.7
2	Аймгийн ХХҮГ	ХХҮГ-аас гаргадаггүй.			ХХҮГ-аас гаргадаггүй.			1,203	380	1128	ХХҮГ-аас гаргадаггүй.		
	Зөрүү	-	-	-	-	-	-	5	12	351	-	-	-

Эх сурвалж: www.1212.mn, аймгийн ХХҮГ-ын www.lmis.gov.mn сайт/программ дахь 2019-2021 оны хөдөлмөр эрхлэлтийн статистик мэдээ, ХНХЯ-наас гаргасан 2019-2021 оны хөдөлмөрийн зах зээлийн судалгаа

Жич: www.1212.mn сайтад бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 2021 оны 02 дугаар сараас хойш гараагүй байна.

Дорнод аймагт бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоон мэдээлэл нь 2019-2021 оны байдлаар 5-351 иргэнээр зөрүүтэй гарсан нь холбогдох мэргэжлийн байгууллагууд болох Үндэсний статистикийн хороо, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамдын мэдээлэл солилцох харилцаа холбоо, дотоод хяналт хангалтгүй байгаатай холбоотой байна.

Мөн Үндэсний статистикийн хорооны www.1212.mn цахим сайтын 2021 оны 2 дугаар сараас хойших мэдээллийн баяжилт хангалтгүй, ХНХЯ-ны www.lmis.gov.mn цахим систем нь хандалт удаан, хөгжүүлэлт хангалтгүй байгаа нь аудитын явцад ажиглагдлаа.

Иймд статистик мэдээний үнэн зөв, бодитой байдлыг хангах, хяналт шалгалтыг сайжруулах, цахим программуудын баяжилт, хөгжүүлэлтийг сайжруулах шаардлага үүссэн байна.

Нэмэлтээр: 9.1. Шилэн дансны тухай хуулийг бүрэн мөрдөж ажиллаагүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн Шилэн дансны цахим хуудсанд хуульд заасан мэдээллийг байршуулсан эсэхийг шалгахад дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

- 2016 онд Шилэн дансны цахим хуудсан байршуулбал зохих 151 мэдээллээс 56 мэдээллийг хуулийн хугацаа хоцроосон, байгууллагын батлагдсан төсөв, аудит дүгнэлт байршуулаагүй.
- 2017 онд Шилэн дансны цахим хуудсан байршуулбал зохих 151 мэдээллээс 29 мэдээллийг хуулийн хугацаа хоцроосон, байгууллагын жилийн эцсийн санхүүгийн тайлан, аудит дүгнэлт байршуулаагүй.
- 2018 онд Шилэн дансны цахим хуудсан байршуулбал зохих 151 мэдээллээс 13 мэдээллийг хуулийн хугацаа хоцроосон, дараа жилийн төсвийн төсөл, батлагдсан төсөв, санхүүгийн тайлан, аудит дүгнэлт байршуулаагүй.
- 2019 он Шилэн дансны цахим хуудсан байршуулбал зохих 151 мэдээллээс 42 мэдээллийг хуулийн хугацаа хоцроож байршуулсан байна.
- 2020 онд Шилэн дансны цахим хуудсанд батлагдсан төсөв, төсвийн төсөл, санхүүгийн хагас жилийн тайлан, төсөл хөтөлбөртэй холбоотой 776,307.8 мянган төгрөгийн мэдээллийг оруулаагүй зөрчилд ТАБ-ын СТА-аар албан албан шаардлага өгсөн.
- 2021 онд Шилэн дансны цахим хуудсан байршуулбал зохих 151 мэдээллээс 19 мэдээллийг хуулийн хугацаа хоцроож байршуулсан зөрчилд ТАБ-ын СТА-аар зөвлөмж өгсөн байна.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:

МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
21000, Чойбалсан, Дорнод аймэг
Утас: 7058-4202, факс: 7058-4584

Ард. 05, 08 № 1/015
таний -ны № -т

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

"Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудит"-ын дүгнэлттэй танилцлаа.

Гүйцэтгэлийн аудитын дүгнэлтээр өгсөн зөвлөмж чиглэлүүдийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, нэмэлт тайлбар мэдээллүүдийг авч боловсруулан хүргүүлж байна.

Аудитын дүгнэлтээр гарсан санал, дүгнэлтүүдийг цаашид орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусган хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллах болно.

Хавсралт: 2 хуудастай

ЗАСАГ ДАРГАЙН
ОРЛОГЧ Ш.ЁЛ

010622400

АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ТАЙЛБАР

2022.05.04.

№	Аудитын чиглэл/агуулга	Алдаа, зөрчлийн товч утга	Тайлбар
1	3.3 Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл нь хууль, дүрэмд заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж байна уу?	Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл нь хууль, дүрэмд заасан чиг үүргээ хэрэгжүүлж ажлаагүй байна.	Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөл нь чиг үүргийнхээ хүрээнд жилд 2 удаа хуралдаж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээрх бусад арга хэмжээ, чиглэлүүдийг коронавирусын халдварт цар тахалтай холбогдуулан цахимаар зохион байгуулсан бөгөөд үйл ажиллагааны зардалдаа хяналт, шалгалтын зардлыг баталж, жилийн эцсээр Зөвлөлөөс томилогдсон гишүүд газар дээр нь очиж, дэмжлэг авсан иргэдийн үйл ажиллагаатай танилцдаг болно. Мөн 2020-2021 онд цар тахал гарсантай холбогдуулан Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийн гишүүдийг Төсөл сонгон шалгаруулах ажлын хэсэгт оролцуулан төслийг цахимаар сонгон шалгаруулж ажилласан болно. Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийн тайланг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын жилийн эцсийн тайланд хавсаргасан бөгөөд Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийн 2022 оны анхдугаар хуралдаанаар үйл ажиллагааг тайлангаж, санал, дүгнэлтийг сонсож "хангалтай" гэсэн үнэлгээг авсан болно.
2	6.2 ХЭДС-ийн хөрөнгийг хууль урмын дагуу зарцуулж, үр нөлөөг тооцсон уу?	ХЭДС-ийн хөрөнгийн 9.2 сая төгрөгийг хууль, журмын дагуу зарцуулаагүй байна.	Үйлдвэрлэл дээрх сургалтыг Хайртүрд ХХК-тай 2019 онд гэрээ байгуулан ажлын байран дээрх сургалтыг зохион байгуулж, 15 иргэнийг хамруулсан. Энэхүү сургалтын анхан шатны бичиг баримтыг дутуу бүрдүүлсэнтэй холбогдуулан цаашид энэ асуудалд анхаарч ажиллах болно. Иймд дээрх асуудалд албан шаардлага тавьж өгнө үү.

ТАЙЛБАР БИЧСЭН: ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

А.МЯГМАРСҮРЭН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2021 ОНЫ 314 ДҮГЭЭР ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТ

2022.05.04.

№	Огноо, дугаар	Заалтын дугаар	Хэрэгжилт
1	2021 оны 10-р сарын 13-ны өдрийн №314	2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан салбар, орон нутгийн түвшинд батлан хэрэгжүүлж байгаа бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийж, хуульд нийцүүлэх арга хэмжээг 2021 оны 12 дугаар сард багтаан авч хэрэгжүүлэхийг Засгийн гарын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасгай.	Дорнод аймгийн ЗДТГ-аас Монгол улсын хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг УИХ-аас 2020 оны 05 дугаар сарын 07-ний өдөр баталсан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэх арга хэмжээг зохион байгууллаа. Энэ хүрээнд Засгийн газрын "Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого батлах тухай" 2016 оны 320 дугаар тогтоол, Дорнод аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан "Дорнод аймгийн 2016-2025 оны хөгжлийн хэтийн зорилт"/Дорнод Сэргэн мандалт/ бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох зорилгоор Чойбалсан хотод 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдөр "Дорнод аймгийн 2016-2025 оны хөгжлийн хэтийн зорилтын хэрэгжилт, цаашдын хандлага" сэдэвт зөвлөгөөнийг зохион байгуулсан. Зөвлөгөөнөөр "ХҮН ТӨВТЭЙ НИЙГМИЙН ХӨГЖЛИЙГ ХАНГАЖ, ХҮН АМЫН ӨСӨЛТИЙГ НЭМЭГДҮҮЛНЭ ОЛОН ТУЛГУУРТ, ТОГТВОРТОЙ ЭДИЙН ЗАСАГТАЙ, ТЭРГҮҮЛЭХ ХӨГЖИЛТЭЙ АЙМАГ БОЛНО. ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ АМЬДРАХ ОРЧНЫГ БҮРДҮҮЛНЭ" гэсэн 3 зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн ажил, нийгэм эдийн засгийн үзүүлэлтүүдийг танилцууллаа. Хөтөлбөрийн хүрээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр ирэх жилүүдэд аймгийн эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүд болох Хүнс, хөдөө аж ахуй, Аялал жуулчлал, үйлчилгээ, Эрдэс баялагийн салбарыг хөгжүүлэхэд шаардагдах орон нутгийн бодлого, хөтөлбөр болон боловсон хүчнийг бэлтгэх, цахилгаан дулааны эрчим хүч, зам харилцаа, дэд бүтцийг барьж байгуулахад орон нутгийн иргэдийг түлхүү оролцуулж, ажлын байраар хангаснаар иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх зорилтыг дэвшүүлсэн болно.

ДОРНОД АЙМГИЙН ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР

САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР:

1. Тайлангийн 3.3 дахь хэсэгтэй холбогдуулан ирүүлсэн тайлбар нь дүгнэлт хэсгийн утга, агуулгаас өөр зүйлийг /цахимаар хуралдаж ажилласан талаарх ажлын тайлан/ тусгасан учир “Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл нь хууль, дүрэмд заасан хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй байна.” гэсэн дүгнэлтийг хэвээр үлдээхээр шийдвэрлэв.

2. Тайлангийн 6.2 дахь хэсэгтэй холбогдуулан ХХҮГ-аас ирүүлсэн тайлбар нь актыг өөрчлөхөд хангалттай баримтаар нотлогдохгүй байгаа тул актыг хэвээр үлдээхээр шийдвэрлэв.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1.1. Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлого, шийдвэрийг аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, аймгийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгасан байна.

1.2. Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээний судалгааг 2018, 2020 онуудад мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн боловч зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж үр дүнг үнэлээгүй байна.

1.3. Дорнод аймагт хөдөлмөр эрхлэлтийн талаар тусгайлсан дунд хугацааны стратегийн бодлогын баримт бичиг батлагдаагүй байна.

2.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг үндэслэлтэй тооцоогүй байна.

2.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг оновчтой тодорхойлж, тусгасан байна.

2.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн санхүүжилтийг нэгдсэн дүнгээр баталж, цаг хугацаанд нь хуваарилахгүй байна.

3.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны төлөвлөгөө уялдсан байна.

3.2. Орон нутгийн онцлогт тохирсон төсөл, хөтөлбөрүүд батлагдсан байна.

3.3. Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл нь хууль, дүрэмд заасан хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.4. Аймгийн ИТХ-аар батлагдсан “Залуу малчин”, “Нэг өрх-Нэг ажлын байр” хөтөлбөрийн хэрэгжилтэд зохих хяналт, шинжилгээ үнэлгээ хийгдсэн байна.

4.1. Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, ажилд зуучлах арга хэмжээнд үр дүнг тооцох нөхцөл бүрдээгүй байна.

4.2. Нэгдсэн бүртгэл, мэдээллийн системийн хөгжүүлэлт хийгдээгүйн улмаас тоо, мэдээлэл нь зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.

4.3. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд зарцуулсан хөрөнгийн үр ашиг бодитой тооцогдохгүй байна.

5.1. Гадаадын санхүүжилттэй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт үр дүнтэй байна.

5.2. Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг бодитой үнэлж ажиллаагүй байна.

5.3. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар тусгайлан авч хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй байна.

6.1. ХЭДС-ийн орлогын төлөвлөгөө 2016-2021 онд дунджаар 91.6 хувийн биелэлттэй байна.

6.2. ХЭДС-ийн хөрөнгийн 9.2 сая төгрөгийг хууль, журмын дагуу зарцуулаагүй байна.

7.1. Орон нутгийн хэмжээнд МБСДС-ийн хөрөнгийг үр ашигтай, үр дүнтэй ашиглаж, нөлөөллийг үнэлэх үйл ажиллагаа хангалтгүй байна.

7.2. Орон нутагт МБС-ын байгууллагын санхүүжилт үр нөлөө багатай байна.

8.1. Цар тахлын үед ажлын байрыг хадгалах талаар Засгийн газраас гаргасан тогтоол шийдвэрийн үр дүнд 1102 аж ахуйн нэгж хөнгөлөлт, чөлөөлөлт, тэтгэмжид хамрагдсан ч зарим ААН-үүд ажлын байраа хадгалж үлдээгүй байна.

8.2. Цар тахлын үед орон нутагт ажилтныг дэмжих чиглэлээр авсан арга хэмжээ үр дүнтэй байна.

8.3. Цар тахлын үеийн сөрөг нөлөөллөөс зорилтот бүлгийн хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг хамгаалах чиглэлээр хөтөлбөрүүд хэрэгжиж, 772 иргэн ажлын байраар хангагдсан байна.

8.4. Цар тахлын улмаас хөдөлмөр эрхлэлтийн салбарт гарсан өөрчлөлт, статистик тоо мэдээг зөрүүтэй байдлаар гаргасан байна.

Нэмэлтээр 9.1. Шилэн дансны тухай хуулийг бүрэн мөрдөж ажиллаагүй байна.

Аудитаар нийт 1 акт, 1 албан шаардлага, 8 зөвлөмж өгч, нэгтгэсэн тайланд тусгуулах 3 санал, хууль, хяналын байгууллагад шилжүүлэх 1 саналыг Үндэсний аудитын газарт хүргүүллээ.

НЭГДСЭН ТАЙЛАНД ТУСГУУЛАХ САНАЛ:

Үндэсний аудитын газарт:

Аудитаар илэрсэн дараах асуудлуудыг шийдвэрлэх талаар холбогдох газарт уламжлах. Үүнд:

2.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн санхүүжилтийг оновчтой хуваарилах талаар холбогдох газарт уламжлах.

4.2. болон 8.4. Хөдөлмөр эрхлэлтийн салбарын статистик мэдээний үнэн зөв, бодитой байдлыг хангаж, хяналт, шалгалт, цахим программуудын баяжилт, хөгжүүлэлтийг сайжруулах талаар холбогдох газарт уламжлах. /ҮСХ, ХНХЯ/

7.1. МБС-ын байгууллагын санхүүжилтийг хувьсах зардлын нормативаар тооцож олгох талаар холбогдох газарт уламжлах.

ХУУЛЬ, ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГАД ШИЛЖҮҮЛЭХ САНАЛ:

Монгол Улсын Ерөнхий аудитор:

5.2. Нийтлэг үйлчилгээний хөрөнгийн зарцуулалттай холбоотой төрийн байгууллагуудын зарим албан тушаалтнуудын арилжааны банкны хувийн харилцах данс руу дамжин орсон, мөн нийтийг хамарсан үйлчилгээнд хамрагдсан иргэдийн данс хооронд ажлын хөлсийг гүйлгэн шилжүүлсэн тохиолдлуудыг хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлд:

1.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр орон нутгийн түвшинд дунд болон богино хугацааны стратегийн бодлогын баримт бичгийг боловсруулж, батлуулах.

3.3. Дүрэмд заасны дагуу улирал бүр хяналт шалгалт хийх чиг үүргээ хэрэгжүүлж, үр дүнг үнэлж, дүгнэх.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт:

2.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн төсвийн төслийг судалгаа, шинжилгээнд үндэслэн боловсруулж байх.

4.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.1, 6.2.2-д заасан нийтлэг үйлчилгээг үр дүнтэй зохион байгуулж, үр дүнг бодитой тооцох.

4.3. Нийтлэг үйлчилгээнд зарцуулж буй хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах.

5.2. Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хөндлөнгийн болон дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээг жил бүр хийлгэж байх.

9.1. Шилэн дансны тухай хуульд заасны дагуу цахим хуудсанд мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулж байх.

Мэргэжлийн боловсролын сүргүүлиудад: /МСҮТ, Политехник коллеж/

7.2. МБС-ийн санхүүжилтийн үр дүн, үр ашгийг нэмэгдүүлэн хөдөлмөр эрхлэлтэд үзүүлэх нөлөөллийг бодитой үнэлж, дүгнэх.

Аудитын 6.2 дахь асуудалтай холбогдуулан ХХҮГ-т акт, албан шаардлага өгөхөөр шийдвэрлэлээ.

Аудитаар өгсөн актыг 2022 оны 12 дугаар 10-ны дотор барагдуулж, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг 2022 оны 11 дугаар сарын 05-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

АКТ, АЛБАН ШААРДЛАГА:

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АКТ	ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА
Төлбөр барагдуулах тухай Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 9 дүгээр зүйлд заасны дагуу "Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд: Дорнод аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 2019 онд Хайртбүрд ХХК-д гэрээний дагуу сургалт зохион байгуулах зардалд 5,670,000 төгрөгийг шилжүүлсэн нь анхан шатны баримтаар нотлогдохгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, аялага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйцлэг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Дорнод аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын 2019 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр баталсан "Үйлдвэрлэл дээрх сургалт зохион байгуулах гэрээ"-ний 2.1-д "Гэрээ байгуулснаас хойш 25 хоногийн дотор сургалтын нийт зардал 70 хувийг, сургалтын үйл ажиллагаа дусч, суралцагчид мэргэжлийн үр чадвар түвшин тогтоох шалгалт өгч тэнцсэн болон ажлын байраар хангагдсан суралцагчийн тоо, сургалтын тайлан мэдээг үндэслэн үлдсэн 30 хувийг Б.Золзаяа дансанд тус тус шилжүүлнэ", 2.4-д "Үйлдвэрлэл дээрх сургалтын үйл ажиллагаанд хяналт тавьж шаардлагатай бол сургалтын үйл ажиллагааг зогсоож, энэхүү гэрээний 4.2-т заасан арга хэмжээг хэрэгжүүлнэ" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна. Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдах этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтлэл өгч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д заасныг үндэслэн ТОГТООХ нь: 1. Анхан шатны баримтаар нотлогдоогүй 5,670,000 төгрөгийг Дорнод аймгийн Төрийн сан дахь орон нутгийн торгуулийн орлогын 100070000952 тоот дансанд төвлөрүүлэх;	2. Актын биелэлтийг 2022 оны 12 дугаар сарын 10-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дорнод аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга Н.Базаррагчаа, нягтлан бодогч Б.Золзаяа нарт хариуцуулав. ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН: АУДИТЫН МЕНЕЖЕР И.СЭМЖИДМАА АУДИТОР С.ЭНХБААТАР
Зөрчил арилгах тухай Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 9 дүгээр зүйлд заасны дагуу "Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд: 1. Дорнод аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт зохион байгуулсан сургалтад тус газрын 3 албан хаагчид 2021 онд томилолтын зардалд 450,000 төгрөгийг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, аялага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйцлэг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 2.1-д "Төрийн албан хаагчийг гадаад улсад болон нэг аймаг, хотоос нөгөө аймаг, хотод, ... тухайн байгууллага болон дээд шатны удирдах байгууллагаас баталсан удирдах, төлөөлөгч, шийдвэрийн дагуу тодорхой хугацаагаар томилон ажиллуулсан нөхцөлд албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр олгоно" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна. 2. Сангаас 2019 онд 3,100,000 төгрөгийн үлдсэн хөрөнгө/зөөврийн компьютер, принтер/ бэлтгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна. Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдах этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хууль хүлээн зориулсан үүрэг биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан зарцуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд баримт нийтлэг үндэслэлийг харгалзана. Үүнд", 4.2.1.11-д заасныг тус тус үндэслэн ШААРДАХ нь:	1. Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 2.1 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах, сангаас хөрөнгө бэлтгэхгүй байх, биелэлтийг 2022 оны 11 дүгээр сарын 05-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх; 2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дорнод аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга Н.Базаррагчаа, нягтлан бодогч Б.Золзаяа нарт даалгав. АЛБАН ШААРДЛАГА ӨГСОН: АУДИТЫН МЕНЕЖЕР И.СЭМЖИДМАА АУДИТОР С.ЭНХБААТАР



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2022 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 11

Чаймбалсан хот

Г

Тайлан баталгаажуулах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.2, 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.
2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Аудитын гуравдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга М.Энхтөр, аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн, Мэргэжлийн боловсрол, сургалтын үндэсний зөвлөлийн Орон нутгийн салбар зөвлөлийн дарга, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга, Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын захирлуудад тус тус хүргүүлсүгэй.
4. Аудитаар тавигдсан төлбөрийн акт, албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
5. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор Я.Зоригт даалгасугай.



Б.БОЛОРТУУЛ

011010015

Тэргүүлэх аудиторов 2022 оны
5 дугаар сарын 5-ны өдрийн
11 дугаар тушаалын хавсралт

Төлбөрийн акт, албан шаардлагын жагсаалт

2022.05.05

№	Байгууллагын нэр	Гүйцэтгэлийн аудитын дугаар	Төлбөрийн акт, албан шаардлагын утга	Мөнгөн дүн /мян.төг/
Төлбөрийн акт				
1	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	АГГ-2022/20-ШТА-ГА	Төлбөр барагдуулах тухай	5,670.0
Албан шаардлага				
1	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	АГГ-2022/20-ШТА-ГА	Зөрчил арилгах тухай	3,550.0
Нийт дүн				9,220.0

